

**Улаанбаатар: ӨНӨӨДӨР**

Өдөр +23  
Шөнө +2

**УЛС ТӨР**

**Ж.ЭРДЭНЭБАТ: ТӨР, ХУВИЙН ХЭВШИЛ ХОЁР ТУСДАА ЯВАХ УЧИРГҮЙ**

**II нүүрт**

**УЛС ТӨР**

**АМЬЖИРГААНЫ ТҮВШИН ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ДҮНГ НЭГТГЭЖ БАЙНА**

**III нүүрт**

Дугаарын **60** мөр  
“Яг түүн шиг”  
шоу яг цагаа  
ОЛЛОО

ЧУУЛГАНЫ ТАНИХМААС

## “АРД ТҮМНИЙ ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦСЭН НЬ ЗӨВ”

Б.ТОГТОХ

Монголд арилжааны болон мэдээллийн телевиз байдгаас 90 гаруй нь үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн тоон мэдээ бий. Цаана нь тусгай зөвшөөрөл авчихсан, үйл ажиллагаа нь алдаг оног явж байгаа хэдэн телевиз байгааг мэдэх аргагүй юм. Оройхон гэртээ орж, амрах зууртаа телевизийн суваг солиод ч үнэндээ үзэх зүйл ховор байдаг нь худлаа биш. Харь орны атаа жетөө, өс хонзон, нус нулимс болсон хэдэн киног л хэдэн телевиз маань өдөр шөнөгүй давтаж гаргана. Цаг үеийн мэдээллийн цагаас өөрөөр монгол контент гэх зүйлгүй явж ирсэн цаг үе байлаа. Харин энэ байдал одоо өөрчлөгдөж байна.

Үргэлжлэл нь III нүүрт



—Зөрчлийн хууль шоронжсон хууль болсон гэв—

Б.ӨНӨРТӨГТӨХ

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан өчигдөр хоёр том хуулийн төслийг хэлэлцэв. Тодруулбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн төслийг хуралдааны эхэнд хэлэлцэж, 74.6 хувийн саналаар дэмжих нь зөв гэж үзлээ. Хуулийн төслийг

талаарх танилцуулгыг Хуульзүйн сайд С.Бямбацогт хийсэн юм. Төслийг хэлэлцэх шатанд УИХ-ын гишүүдээс шийдвэр гүйцэтгэлийн ажилчдын урамшуулал хэвээр олгогдох эсэх болон шүүхийн

шийдвэрээр хураагдсан эд зүйлсийг хэрхэн үнэлэх вэ гэсэн асуудлыг тодруулав. Харин хууль санаачлагчид урамшуулалтай холбоотой хуулийн заалтыг халсан. Харин шүүхийн шийдвэрээр

хураагдсан эд зүйлсийг хөрөнгийн үнэлгээ гуравны нэгээр буурах тохиолдолд шинжээч тогтоох шаардлагатай гэж тусгасан. Нэг сарын дотор ч гэдэг юм уу, нарийвчлан туссан гэсэн харилт өглөө. Энэ мэтээр санал хэлж, асуулт асууж дууссан учраас хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр байнгын хороонд шилжүүлээ.

Ц.Элбэгдорж: Иргэдийн нүд чихийг боож болохгүй

Чуулганы хуралдааны дараагийн анхаарал татсан хууль бол Зөрчлийн тухай хууль. Хэвлэл мэдээлэл, цаашлаад иргэдийн мэдэх эрхэнд халдаж, эх сурвалж, баримттай ч иргэний нэр төрд халдсан бол гүтгэсэн гэх зүйл заалтаар торгууль ногдуулах, мөн гудамж талбайд хог хаявал торгох заалт агуулсан энэхүү хуулиар өчигдрөөс эхлэн чөлөөт хэвлэлийнхэн эсэргүүцэл илэрхийлсэн.

Үргэлжлэл нь II нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## ХЭН ЮУ ХЭЛЭВ

Э.ТУУЛ

Энэ удаагийн “Хэн юу хэлэв” булангаа хүргэж байна.

**Х.Бадамсүрэн: Шахааны Эрдэнэт биш, шилэн данстай, тунгалаг үйл ажиллагаатай Эрдэнэт байх болно**

“Эрдэнэт үйлдвэр” компанийн Ерөнхий захирал/ Энэ жил уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ой тохиож буйтай холбогдуулан уул уурхайн салбарын төвийн бүсийн чуулга уулзалтыг Орхон аймагт хийх болсон

тухайгаа мэдээллийг УУХУЯ-ны удирдлагууд өгсөн. Энэ үеэр сүүлийн үед олны анхаарлыг татаад буй “Эрдэнэт үйлдвэр” компанийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн сэтгүүлчдийн асуултад хариулсан юм. Тэрбээр “Эрдэнэт үйлдвэр” хэмнэлтийн бодлого барьж ажиллаж байгаа. Манай үйлдвэр хоногт 1.5 сая ам.долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Ерөнхий захирлын тавилга, машин гэх мэт асуудлаар шуугиан дэгдээх сонирхол байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр “Эрдэнэт үйлдвэр”-ийн өмнөх захирлын машин өөр газар шилжих болж, түүний оронд шинэ машин авах болсон. Шинэ машин авах үе нь миний ажил авсан үетэй таарсан хэрэг.

Түүнээс Ц.Даваацэрэн захирал үргэлжлүүлээд ажилласан бол энэ машиныг л унах байсан. Өөрөөр хэлбэл, Дорж очсон ч шинэ машин унах байсан юм шүү дээ. Миний хувьд тансагладаг, машин унаа үзээгүй мэтээр хандаагүй гэдгийг хэлмээр байна. Намайг компанийн ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналаар томилсон. “Эрдэнэт үйлдвэр” компанийн ерөнхий захирал, орлогч нарт өмнө нь шинээр байр бариад өгсөн тохиолдол байсан юм билээ. Тэр жишгээр явсан юм шүү дээ. Түүнээс Х.Бадамсүрэн гэдэг хүн очоод гэнэт тансагласан жишг гаргасан зүйл байхгүй.

Үргэлжлэл нь III нүүрт

ДЭЛХИЙ

## Эммануэль Макрон / Марин Ле Пен



Б.ДАВАА

Францад Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шат энэ сарын 23-нд болж, Эдийн засгийн сайд асан Эммануэль

Макрон, “Үндэсний фронт” намын тэргүүн Марин Ле Пен нар шийдвэрлэх шатанд тунаж үлдсэн. Тэдний хувьд тун ойролцоо хувийн санал авсан байдаг.

Үргэлжлэл нь IV нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ



## ТОП-100 ШАЛГАРУУЛАЛТАД М-СИ-ЭС ГРУППИЙН 11 КОМПАНИ ШАЛГАРЧ, ӨНГӨРСӨН ЖИЛИЙН АМЖИЛТАА БАТАТГАЛАА

А.ЛУНГАЛАГ

Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ хамтран өнгөрсөн онд манай улсын эдийн засаг, бизнес, нийгмийн салбарын хөгжил, улсын төсвийн бүрдүүлэлтэд жинтэй хувь нэмэр оруулсан ТОП-100 аж ахуйн нэгжийг шалгаруулж цом, өргөмжлөл гардуулах ёслолыг Төрийн ордонд зохион байгууллаа. 16 дахь жилдээ зохион байгуулагдсан энэхүү шалгаруулалт нь улс орны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй үндэсний шилдэг компаниудын бүтэн жилийн үйл ажиллагаа, ололтыг үнэлж дүгнэдэг, цаашдын амжилтад нь урам зориг нэмдэг нэр хүндтэй ёслол юм.

ТОП-100 аж ахуйн нэгжийг шалгаруулахдаа, бизнесийн байгууллагууд тухайн жилд улсад төлсөн татвар, борлуулалтын орлого, ажиллагсдын тоо, ашгийн хэмжээ, хөрөнгийн хэмжээ гэсэн үзүүлэлтээр дүгнэж байр эзлүүлжээ. Үзүүлэлтийг дүгнэхдээ, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудаас ирүүлсэн тоо баримт дээр үндэслэн тодорхой аргаачлалыг дагуу шалгаруулсан байна.

2016 оны ТОП-100 шалгаруулалтад үндэсний групп компаниудаас М-Си-Эс группийн 11 компани шалгарч, өнгөрсөн жилд хүрсэн амжилтаа дахин бататгасан нь онцлох үйл явдал боллоо. Тухайлбал, энэ удаад М-Си-Эс Холдинг ХХК, М-Си-Эс Интернэйшл ХХК, Юнител ХХК, М-Си-Эс Кока-Кола ХХК, М-Си-Эс Проперти ХХК, М-Си-Эс Азия Пасифик Брюэри ХХК, Спирт бал бурам ХХК, СББ Трейд ХХК, Шангри-Ла Улаанбаатар ХХК, Юнивишн ХХК, Анунгоо ХХК-нд шалгарчээ. Тус групп нь 2016 онд нийтдээ 229 тэрбум төгрөгийн татвар, шимтгэл төлсөн бөгөөд сүүлийн 6 жилийн байдлаар 1,3 их наяд төгрөгийн татвар, шимтгэлийг Монгол Улсынхаа санд оруулжээ. Өнгөрсөн онд М-Си-Эс группийн компаниуд эх орныхоо хөгжил дэвшилд бодит хувь нэмэр оруулах, татварын бааз суурийг нэмэгдүүлэх томоохон бүтээн байгуулалтуудыг цогцлоож ашиглалтад оруулжээ. Тэдгээрээс онцолж хэлбэл,

“Монголд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, Улаанбаатар хотын дүр төрхийг шинэчлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан, 5 одтой зочид буудал болон А зэрэглэлийн оффис, орон сууц, худалдааны төв, иж бүрэн тоноглогдсон спорт клуб, үзвэр үйлчилгээ зэргээс бүрдсэн дэлхийн

хэмжээний өндөр зэрэглэлтэй Шангри-Ла цогцолбор, “Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд өргөсөн АСЕМ-ын дээд хэмжээний 11 дэх уулзалтад хүрэлцэн ирсэн гадаадын төр засгийн тэргүүнүүд, хүндэт зочдыг байрлуулсан, олон улсын “International Property Awards 2016” шалгаруулалтын “Шилдэг, шинэ орон сууцны бүтээн байгуулалт” номинацийн шагналтай АСЕМ хотхон, 4G LTE сүлжээг Юнител групп Монгол орон даяар анхлан нэвтрүүлж, 21 аймаг, 330 суманд хүргэсэн нь өргөн уудам газар нутагтай боловч тархай суурьшсан, цөөн хүн амтай манай улсын хувьд технологийн маш том бүтээн байгуулалт юм. Ингэснээрээ Монгол Улс өндөр хурдны, хөдөлгөөнт интернетын 4G LTE сүлжээг орон даяараа нэвтрүүлсэн дэлхийн эхний 25 орны тоонд багтаж чадсан зэрэг томоохон бүтээн байгуулалтуудыг нэрлэж болно юм.

Үндэсний инженер, техникийн ажилтан, ажилчдын мэргэжлийн өндөр ур чадварыг сорьсон эдгээр бүтээн байгуулалтын далайцтай үйл ажиллагаанд дотоодын 500 орчим компанийн 10,000 гаруй хүн ажиллажээ.

ХААН банк				Худалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2415.00	2429.00	ФУНТ	3064.00	3158.00	АМ.ДОЛЛАР	2416.00	2428.00
ЕВРО	2605.00	2673.00	РУБЛЬ	41.50	43.60	ЕВРО	2606.00	2672.00
ИЕН	21.63	21.92	ЮАНЬ	349.00	352.10	ИЕН	21.46	22.04
						ФУНТ	3071.00	3146.00
						РУБЛЬ	41.23	44.29
						ЮАНЬ	349.50	352.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

## УЛС ТӨР

ЧУУЛГАНЫ ТАНИХМААС

## “АРД ТҮМНИЙ ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦСЭН НЬ ЗӨВ”

–Зөрчлийн хууль шоронжсон хууль болсон гэв–

Төгсгөл.

Түрүүч нь I нүүрт

Улмаар өдөр тутмын сонинууд эхний нүүрээ харлуулж, телевизүүд ч нэг цагийн турш улс төрийн мэдээ мэдээлэл дамжуулахаас татгалзж эфирээ харлуулсан. Цахим сайтууд ч энэ эсэргүүцэлд нэгдсэн нь улстөрчдийг сандрааж орхин. Тиймээс Зөрчлийн тухай хуульд тэд анхаарал хандуулж, Ерөнхийлөгч хүртэл байр сууриа илэрхийллээ. Хуулийн төслийг хэлэлцэж эхлэхэд АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат завсарлага авах хүсэлтээ гэдгээ хэлсэн юм. Тэрбээр, шалтгаанаа “Зөрчлийн хуулиар зургаан гэмт хэргийн шинжтэй асуудал оруулж ирсэн. Зөрчил дээр ажлын хэсгээс баривчилгааны тухай асуудлыг оруулж ирсэн. Орж ирж байгаа заалтуудын 50 гаруй хувь нь найруулгын хувьд өөрчлөгдөж, үг хэллэгийн хувьд ойлгомжгүй зүйл их орж ирлээ. Зөрчил гаргасан хэнийг ч болов дурын нэгэн хэн нэгэн байцаагч, түшмэл дураараа торгох эрх нь нээгдэж байгаа зэрэг ноцтой зүйлүүд их гарч байна. Тиймээс бид энэ хуулийг энэ удаад хэлэлцэхгүй хойшлуулах хэрэгтэй гэж харж байна” хэмээв. Улмаар, УИХ-ын дарга М.Энхболд Д.Эрдэнэбат гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулсан ч үргэлжлүүлэн хэлэлцэх ёстой гэж үзлээ. Тэгвэл энэ асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ын чуулганд үг хэлсэн нь мөн л анхаарал татах сэдэв байлаа. Тэрбээр, “Төрийн зүгээс шийдэж байгаа учраас иргэд, аж ахуйн нэгж, бүтээгчдийн талыг барьж ажлаа хийх хэрэгтэй. Энэ

...Монголын тэр дундаа сэтгүүлзүйн түүхэнд байгаагүй хараар тэмдэглэн үлдэх үйл явдал энэ парламентын үед гаргалаа. Энэ үйлдлийг хэвлэл мэдээллийн байгууллагууд эсэргүүцсэн нь зөв. Ард түмний үнэнийг мэдэх эрх ашгийн талд зогслоо гэж харж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, олон нийт цочирлоо...

чиглэл рүү анхаарах хэрэгтэй байх гэж бодож байна. Шүүхэд асуудал очсон л бол шийдвэрлэх хэрэгтэй. Шүүхэд дутуу материал ирүүлдэг, мөрдөн байцаах байгууллагуудын дутуу хийсэн зүйлийг дахин буцааж, иргэд, аж ахуйн нэгжийг хохилоодог болох хэрэгтэй. Иргэдийн эрх, үзэл бодлоо чөлөөтэй хэлэх эрхийн асуудал хөндөж байна. Энэ үнэт зүйлээ хамгаалсан байдлаар шийдвэр гаргах хэрэгтэй. Төрд эхлээд хариуцлага бий болгоё. Төрд алба хашиж байгаа хүмүүс дээр ёсзүйн дүрэм гаргах хэрэгтэй. Нүд, чих болсон иргэдийн эрхийг боомилсон ямар нэг заалт оруулж болохгүй. Ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж яриад байгаа фэйсбүүк, твиттерийн талаар яригдаж байна. Үүнийг

техникийн аргаар зохицуулж болно. Гэтэл хамгийн бүдүүлэг аргаар торгоно, шийтгэнэ гэдэг бол буруу зүйл. Торгууль нэмлээ гэдэг дээр шуугиан болж байна. Торгууль нэмэх саналаа татаж авлаа гэхээр үндсэн санал нь үлдэж байна. Үндсэн саналаа ч татаж ав. Өөрсдийгөө тойрсон ёсзүйн, хариуцлагын хуулиа батлаагүй байж, иргэдийн нүд, чихийг боож болохгүй. Ухаалаг улстөрчид өөрсдийн үйлдлээ хянаад хэвлэл мэдээллээр гарсан зүйл албан тушаалтнуудад хэрэгтэй байдаг. Хэрвээ гүжирдлэг байвал няцаах эрх нь байгаа. Энэ заалтыг бүрэн хүчингүй болгох хэрэгтэй. Улс төрийн алба хашиж байгаа хүн гомдол гаргаад явдаг заалтыг хасах хэрэгтэй. Иргэний хувиар гомдол гаргах эрх нь бүрэн нээлттэй байгаа шүү” хэмээн байр сууриа илэрхийлсэн юм. Мөн гадны банк санхүүгийн байгууллага Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрхийг олгох Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийг УАБЗ-өөр оруулж хэлэлцүүлэх ёстой гэсэн байр суурь илэрхийллээ.

Д.Сарангэрэл:

Сэтгүүлзүйн түүхэнд хараар тэмдэглэгдэх үйл явдал боллоо

Зөрчлийн тухай хуульд хэвлэл мэдээлэл болон иргэдийн мэдээлэл түгээх, хардах эрхийг онц ноцтой зөрчиж, улмаар баримттай байхаас үл шалтгаалан зөрчил гаргасан хэмээн хувь хүнийг 20, байгууллагыг 100 сая төгрөгөөр торгох заалтаас гадна хүүхдээр хөдөлмөр эрхлүүлсэн бол, мөрийтэй тоглоом зохион байгуулсан, түүнд уруу татсан, бэлгийн замын өвчин бусаддаа тараасан, гудамжинд хог хаяж, нус цэрээ хаясан бол зөрчил гэж үзэн нэгжээр тооцож мөнгөн торгууль ногдуулахаар болсон байна. Үдээс хойшхи хуралдаан ч

эдгээр сэдвүүдийг тойрч өрнөлөө. Нийгэмд аюулын харанга дэлдэн, мэдээлэх эрхээ хамгаалахын төлөө тэмцсэн хэвлэл мэдээллийн эсэргүүцэл тэдэнд нэгийг сануулсан нь тодорхой байлаа. Тиймдээ ч танхимд ирц хангалттай, гишүүд ч хуулийг тун няхуур хэлэлцлээ. Гишүүдийн хэлсэн үгнээс тоймлон хүргэе.

Д.Сарангэрэл: Монголын тэр дундаа сэтгүүлзүйн түүхэнд байгаагүй хараар тэмдэглэн үлдэх үйл явдал энэ парламентын үед гаргалаа. Энэ үйлдлийг хэвлэл мэдээллийн байгууллагууд эсэргүүцсэн нь зөв. Ард түмний үнэнийг мэдэх эрх ашгийн талд зогслоо гэж харж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, олон нийт цочирлоо. Ийм байдалд хүргэснийхээ төлөө улстөрчид уучлал гуйх ёстой. Монголын төрийн парламентын нэр хүндийг сэвтүүлээ. Хэвлэлийн түүхэнд ийм үйл явдал гарч байсан ч олноороо эсэргүүцэл илэрхийлж байсныг санахгүй байна. Улстөрчид бие биеэ хаацайлдаг. Чингис бондоос хэн нь хэдийг авсныг бодитойгоор мэдэхгүй байгаа. Үүнийг хаах, санхүүжилтээр нь боож хэвлэл мэдээллийг боомилох гэсэн санаа гэж хэвлэлийнхэн үүнийг дүгнэж байгааг буруу гэхгүй. Бичсэн сэтгүүлчийг нь мөшгөөд явдаг. Гүтгэхийг хэн ч дэмжихгүй байгаа. Сэтгүүлч санаатайгаар хүн гүтгэдэггүй. Яарч даараад сонин нь буух, телевизийнхний хувьд цаг нь болох гээд алдаг онодог юм бий. Хэрэв тэгсэн бол алдааныхаа төлөө уучлал гуйх ёс зүйн зөвлөлийг байгуулаад ажиллаж байгаа. Хууль өнөөдөр хэнд үйлчилдгийг бүгд мэднэ. Эрх мэдэлтэй мөнгөтэй хүнд үйлчилдэг. Парламентын 76 гишүүн бүгдээрээ торгуулийг өсгөхөөр ажилласан гэж бодожгүй байна. Дөрөв таван гишүүн төгөлдөр хуур дарсан, бусад нь мэдээ ч үгүй байгаа. Сэтгүүлчийн бичсэн материалыг биш сэтгүүлчийг шалгадаг тогтолцоо байж болохгүй.

М.Оюунчимэг: Ц.Гарамжав гишүүн саналаа татаж авсанд

талархаж байна. Гүтгэлэг гэдэг үгний юу гэж ойлгох вэ гэдгээ сайн зааж огөх шаардлага байгаа. Хардах, мэдээллийн араас мөшгөх үүрэгтэй. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүргийг хязгаарласан үйлдлийг хийж болохгүй” хэмээн байр сууриа илэрхийлсэн юм.

Лу.Болд: Монгол Улсад ардчилсан хувьсгалаар буюу бүхэл бүтэн нийгмийн хувьсгалаар бий болсон хамгийн том ололт болох хүний эрх, эрх чөлөө, хүний эрхийг хангах нөхцөл өнөөдөр маш их дордуулсан хууль гарах гэж байна. Засгийн газар энэ хуулийг оруулж ирэхдээ дотор нь зарим нэг гэмт хэргийг зөрчил гээд зөрчил рүү оруулаад, уяад өгчихсөн. Гэтэл ажлын хэсэг үүнийг нь өргөжүүлээд 10 гаруй хэрэг болгочихсон. Та бүхэн тоолоод үзээрэй. Энэ Зөрчлийн хуулиар зохицуулах гээд байгаа бүх зөрчлийн 80 хувь нь баривчлах ялттай байна. Тэгэхээр энэ Зөрчлийн хууль чинь зөрчлийн захиргааны хууль биш, шоронгийн хууль болчихлоо. Өөр нэг ноцтой асуудал нь энэ хууль Зөрчлийн хууль нэртэй боловч жижиг гэмт хэргийн Эрүүгийн хууль болчихсон байна. Ингээд Зөрчлийн хууль, Эрүүгийн хууль болж байгаа учир прокурор хяналт тавих болно. Ийнхүү прокурор хяналт тавих учир асуудлыг яг гэмт хэргийн шиг авч үзээд, дуртай хүнийхээ эрхийн хязгаарлах, дарамтлах, авлига нэхэх, барьцаанд оруулах зэрэг эрхээ олж авч байгаа юм. Монгол Улсыг эргээд шоронжсон улс болгох хуулийг боловсруулаад, оруулаад ирлээ. Засгийн газрын оруулж ирсэн энэ хуулиар Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж бүр уг хуулийн хамааралтай этгээд болох нь. Тиймээс бүгдээрээ байнга прокурор, цагдаа гээд хуулийн байгууллагын үүдэнд уяатай байх юм байна. Ер нь нэг ч асуудлыг Иргэний, Захиргааны чиглэлээр шийдэх бололцоо байхгүй нөхцөл рүү очиж байгаа шүү.

Д.Эрдэнэбат: Энэ хууль АН-ын эсвэл МАН-ын хууль биш. Энэ бол Монгол хүний эрхтэй холбоотой асуудлыг бид буюу 76 гишүүн

намаас үл хамааран хэлэлцэх ёстой. Тиймээс энэ хуульд хүний эрхтэй холбоотой зөрчлөөр үүсч байгаа олон буруу, дутуу зүйлүүд байгаад байна гэдгийг бүгдээрээ эргээд нэг хараач. Үүнийг би чин сэтгэлээсээ та бүхнээс хүсч байна. Хуулиа хойшлуулаад, хэдүүлээ нэг ойлголцоод, эв чингээд нь оруулах хэрэгтэй байна. Хоёрдугаарт, баривчлах гэдэг заалтыг доо шинээр оруулж ирж байгаа нь Зөрчлийн хуулийн үзэл санааг бүр өөр тийш нь татаад аваад явчихлаа. Энэ хууль чинь Зөрчлийн тухай хууль биш. Харин жижиг гэмт хэргийн тухай хууль болчихлоо. Харин баривчлах гэхийн оронд түр саатуулах гэсэн бол хүн ойлгоно. Мэдээж зайлшгүй шаардлагатай тохиолдолд түр тусгаарлах шаардлага байгаа бол үүнийг хэдүүлээ ярилцах хэрэгтэй байна. Ингээд эрүүлээр ярилцахгүй зөвхөн орж ирсэн асуудал бүрийг итгэл үнэмшил гээд бооноороо кноп дараад, нийгмийн бухимдлыг төрүүлээд байх юм.

...Хуралдааны төгсгөлд Зөрчлийн тухай хуульд тусгасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулсан ч баривчлах асуудлыг оруулж ирснээс болж маргаан үүслээ. Өөрөөр хэлбэл, Х.Нямбаатар нарын гишүүдийн өөрчилж оруулж ирсэн хууль хуулай, танхай зэргийг Эрүүгийн хэргээс гаргаж, улмаар Зөрчлийн хуулиа оруулахдаа шаардлагатай гэвэл баривчлах ёстой хэмээн оруулж ирсэн нь маргаанаас үүдэж, Зөрчил үүслээ гэж торгох ёстой болохоос баривчлах гэж оруулаад ирэхээр энэ чинь эрүүгийн хууль болно гэсэн маргаанаас үүдэж, хоёр ч удаа санал оруулж дэмжлэг авч чадалгүй унасан юм. Түүнчлэн, гүтгэх зүйл заалтаар сэтгүүлч болон хэвлэлийн эзэд, твиттер, фэйсбүүк хуудсаар иргэд мэдээлэл хуваацаж хүн гүтгэвэл 10-100 сая төгрөгөөр торгох зүйл заалтыг гишүүдийн олонхи дэмжсэнгүй. Энэ мэт зарчмын зөрүүтэй санал үргэлжилсээр 18.00 цаг хүрсэн учраас чуулганы хуралдааныг дуусгаж, өнөөдөр үргэлжлэн хэлэлцэх юм.

МЭДЭЭЛЭЛ

## МАН ирэх сарын 3-нд Бага хурлаа товложээ

МАН-ын Удирдах зөвлөл өнгөрөгч лхагва хуралдаж, ирэх тавдугаар сарын 3-нд Бага хурлаа хийхээр товложээ. Бага хурлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг тодруулах юм байна. Тус нам өнгөрсөн хугацаанд Ерөнхийлөгчид хэнийг нэр дэвшүүлбэл ялалт авах боломжтой вэ гэдэг судалгааг хийсэн байна. Тиймээс судалгаанд үндэслэсэн нэр дэвшигчээ Бага хурлаар оруулж, шийдэх юм байна. Бага хурал нь 310 гишүүнтэй юм. Эх сурвалжийн мэдээлж буйгаар намын дарга М.Энхболдоос гадна Ө.Энхтүвшин, Ц.Нямдорж нарын нэр яригдаж байгаа билээ. Түүнчлэн, Удирдах зөвлөлийн хурлаар Зөрчлийн тухай хуультай холбоотой хэвлэл мэдээлэл эсэргүүцэл илэрхийлсэн асуудлыг хөндөж, сонгууль дохож буйг энэ үед намын нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн ийм үйл явдал гаргасанд нэр бүхий гишүүдийг шүүмжилсэн сурагтай.

**ММINFO**

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчлаганы алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, Чөлөөт хэвлэл сан-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Монгол Улсын эдийн засаг, бизнесийн салбарт амжилт гарган, бусдыгаа манлайлан яваа 2016 оны “ТОП-100” аж ахуйн нэгжид шагнал гардуулах арга хэмжээ Төрийн ордонд боллоо. Улсынхаа дотоодын нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувийг бүтээж, нийт ажлын байрны 90 хувийг хангаж буй шилдэг компанийнхан удирдлагуудад Монгол Улсын

## Ж.Эрдэнэбат:

## ТӨР, ХУВИЙН ХЭВШИЛ ХОЁР ТУСДАА ЯВАХ УЧИРГҮЙ

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат шагнал гардуулж, компанийн баг, хамт олонд баяр хүргэж үг хэллээ.

Тэрбээр, Бизнесийн салбарынхан дотоод нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувийг бүтээж, ажлын байрны 90 хувийг хангаж байна. 2016 оны ТОП аж ахуйн нэгжээр шалгарсан 100 компани гэхэд л татварын орлогын талаас илүү хувийг бүрдүүлж байна. Энэ гуравхан статистикаас харахад Монгол Улсын эдийн засгийн ч, монголчуудын амьдралын ч ачааны хүндийг үүрч байгаа нь манай бизнесийнхэн, энд цугларсан Та бүхэн юм. Засгийн газрын тэргүүний хувиар ард түмнийхээ өмнөөс гүн хүндэтгэлтэйгээр талархлаа илэрхийлж байна. Төр засаг, улстөрчдийн алдаатай бодлогын уршаар эдийн засгийн хямралыг хамгийн түрүүнд мэдэрдэг, түүнд хамгийн гүн гүнзгий өртдөг нь хувийн

хэвшлийнхэн юм. Өнгөрсөн хугацааны тэдгээр алдааны өмнөөс мөн “Уучлал” гуйхын ялданд алдаг давахгүйн төлөө манай Засгийн газар хичээж ажиллаж байгаа, цаашид илүү зүтгэж ажиллах болно гэдгээ илэрхийлэе.

Бизнес эрхлэхэд амаргүй. Тэр тусмаа тогтолцоо нь бүрэн бүрдээгүй, төрийн хүнд суртал байгаа өнөөгийн нөхцөлд 20 гаруйхан жилийн түүхтэй Монголын бизнесийн салбар өднй зэрэгтэй яваа нь бизнесмэнүүд та бүхний асар их сэтгэл, хөдөлмөрийн үр дүн. Өнөөдөр бид энэ танхимд шилдгийг шалгаруулж, шилдэгт шагнаж гардуулахаар цугларсан ч цаашид яаж илүү амжилтад хүрэх, үүний тулд төр, хувийн хэвшлийн хэн нь юу хийж, ямар үүрэг хүлээх ёстой, яаж хамтарч ажиллах талаар зарим санаа хэлэе. Монголын бизнес бусадтай эн зэрэгцэн хөгжихөд хамгийн их саад болж байгаа

гурвын зэрэг шалтгааныг яаралтай засаж залруулах ёстой. Минийхээр, бизнесийн орчныг илүү сайжруулах, төрийн хэт оролцоог хумих, олон түмний сэтгэлгээг өөрчилж чадвал Монголын бизнесийн салбар өнгөрсөн 20 гаруй жилийн түүхээсээ ч ихийг бүтээж, улсынхаа эдийн засагт өнөөдрийнхөөс хувь нэмрээ хэдэн арав дахин илүү оруулж чадна гэдэгт итгэлтэй байна. Бизнесийн орчныг сайжруулах нь манай Засгийн газрын стратегийн зорилт байх болно. Бизнесийн орчныг сайжруулснаар хөрөнгө оруулалт, ажлын байрнэмэгдэнэ. Бизнесийн орчин сайжирснаар иргэдийн амьдрал дээшилнэ, эдийн засаг өснө. Жижиг, дунд үйлдвэрлэл ч, дэлхийд өрсөлдөх үндэсний компани ч бизнесийн сайн орчноос л төрнө. Томорсон, эсвэл түрүүлж бизнесээ эхэлсэн нь биш, бүх нийтээрээ амжилтад хүрдэг таатай орчин бүрдүүлэх,

тийм орчин бүхий компанийн засаглал, менежментийг Монголдоо нутагшуулах, түгээн дэлгэрүүлэхэд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа маш чухал юм. Бид бизнесмэнүүдээ “зөвхөн өөртөө мөнгө хийж байгаа эзэн” гэж харахаа хэзээ болино, тэр цагт энэ сэтгэлгээ өөрчлөгдөнө. Бид нийгмээрээ бизнесмэнүүдээ баялаг бүтээгчид, ажлын байр бий болгогчид гэж харах ёстой, тэгж харах үнэлэх цаг нь болсон гэж бодож байна.

Мөн “Монгол Улсаа хөгжүүлэхийн төлөө хамтран зүтгэж ажиллах, нэр төртэй амьдрахаас өөр сонголт бидэнд байхгүй. Бид хамтарч, харшдан биесээ нөхөн зүтгэж чадвал Монголын маань эдийн засаг тун удахгүй эх орны минь цэцмэг хөх тэнгэрийн нар шиг гэрэлтэх болно гэдэгт итгэлтэй байна. Та бүхнийхээ болон таны баг хамт олны ашиг орлого арван байхын ерөөлийг дэвшүүлэе” гэлээ.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр



# ХЭН ЮУ ХЭЛЭВ

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Мөн “Эрдэнэт үйлдвэр” 40 шахам жил Монгол-Оросын хамтарсан статустайгаар ажиллаж ирсэн. Энэ үед эрдэс баялгийг ухааж авахаас илүүтэй нийгмийн болон бусад асуудлыг цогцоор нь шийддэг хэлбэрээр явсан байдаг. Тиймээс өнөөдөр ажиллаж байгаа ОХУ-ын мэргэжилтнүүдэд хүндэтгэлтэй хандах ёстой. Энэ нь өнгөрсөн оны зургадугаар сард өөрчлөгдсөн. Төр, нийгмийн итгэлийг хүлээн ажиллаж байгаа хүний хувьд маш болгоомжтой хандах учиртай. Одоогоор ОХУ-ын 270 гаруй гэрээт мэргэжилтэн ажилладаг. Үйлдвэр үндэсний хэмжээний болсон учраас мэргэжилтнүүдийг эх оронд нь буцаах, монгол хүнийг ажлын байртай болгох ажлыг үе шаттайгаар хийж байна. Ирэх оны нэгдүгээр сар гэхэд гадны мэргэжилтнийг 150 болгохоор зорьж байгаа. Мэдээж ОХУ-ын талтай ярилцаж асуудал бий. Тиймээс орос хүнийг нарийн бичгээрээ ажиллуулан үе шаттай хэрэгжүүлэх асуудлыг хариуцуулсан юм. Мөн манай үйлдвэрийн бүрэлдэхүүнд орос сургууль, цэцэрлэг ажиллаж байна. Үүнийг үргэлжлүүлэхийг нутгийн иргэд болон ажилтнууд хүсч байгаагаа илэрхийлсэн. Үүнээс гадна “Эрдэнэт үйлдвэр” компанийн статус өнгөрсөн оны зургадугаар сард өөрчлөгдөн Оросын талын эзэмшиж байсан 49 хувийг “Монголын ээс” корпораци худалдан авснаар шинээр ТУЗ-тэй болсон. Ингээд компанийн бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, ерөнхий захирал болон нэгдүгээр орлогч нь тус тусдаа ажлын албатай байхаартомъёолсон байдаг. Харин би нэгдүгээр орлогчтойгоо яриад “тус, тусдаа ажлын албаар яахав дээ, үйлдвэр нэгдмэл бодлоготой, зангидсан гар шиг ажиллах ёстой” гэж шийдсэн. Ингээд нэг ажлын алба байгуулсан. Гэхдээ тэдгээр зөвлөхүүд надад зөвлөхөөс илүү үйлдвэрийн хэлтэс газруудын уялдаа холбоог хангаж ажиллах, том төслийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Тухайлбал, зөвлөх н.Бямбадорж гэж хүн бий. Энэ хүн ил уурхайн даргаар 20 гаруй жил ажилласан. Тэр “Эрдэнэт үйлдвэр”-ийн баяжмалыг хайлуулах, боловсруулах асуудлыг хариуцаж. “Эрдэнэт үйлдвэр”-г “Засвар механикийн завод” гэж байдаг. Энэ завод нь зөвхөн “Эрдэнэт үйлдвэр”-г хэрэгтэй техник хэрэгсэл хийдэг. Бидний цаашид зорилго бол Монгол Улсын засвар, механикийн завод болгож, машинт үйлдвэрийн суурийг тавих явдал юм. Тиймээс энэ төслийг хариуцаж байгаа. Өөрөөр хэлбэл, зөвлөх гээд байгаа хүмүүс маш хариуцлагатай төсөл хөтөлбөр дээр ажиллаж байгаа гэж ойлгож болно” гэсэн юм. Мөн тэрбээр “Зөвлөх 10 сая ам.долларын цалин авдаг гэсэн мэдээлэл гарсан. Үнэндээ тийм асуудал байхгүй. Үйлдвэрээ, салбараа мэддэг хүмүүс л энд ажилладаг. Тэд дунджаар 2.5 сая төгрөгийн цалин авдаг. Үүнийг албан ёсоор мэдэгдэж байна. Түүнчлэн би өнөөдөр тогтоож өгсөн гурван сая төгрөгийн цалин авч байгаа. Дахиад хэлье. ТУЗ-ийн өмнөх болон одоогийн гишүүд “Эрдэнэт үйлдвэр”-ээс доллар байтугай нэг ч төгрөгийн цалин аваагүй. Энэ нь манай компанийн санхүүгийн баримтаар нотлогдоно” хэмээгээд цаашид гархааны бизнес гэдэг асуудал гаргаагүй, шахааны Эрдэнэт биш, шилэн данстай, тунгалаг

үйл ажиллагаатай Эрдэнэт байх болно гэдгийг хэлсэн юм.

## Б.Галаарид: Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд эсэргүүцэж буй нь гурван том шалтгаантай

*/Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Ерөнхийлөгч/ УИХ-ын гишүүн Ц.Гарамжав хэвлэл мэдээллийн хэрэгсэл, твиттер, фэйсбүүкээр хүн гүтгэвэл 2-20 сая төгрөгөөр торгох байсан хуулийн заалтыг 10-100 сая болгох санал гаргаж, Зөрчлийн тухай хуулийн төсөлд тусгуулсан. Хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ асуудлыг эсэргүүцсний улмаас тэрбээр ХЗБХ-ны хурал дээр гаргасан саналаа татах шийдвэр гаргаснаа мэдэгдэв. Тэгвэл өчигдөр сэтгүүл зүйн салбарын төлөөллүүд “Өдрийн сонин”-ы “Асуух эрхийн танхим”-д Зөрчлийн хуулийн талаар хэлэлцэж, байр сууриа илэрхийлсэн. Энэ үеэр Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Ерөнхийлөгч Б.Галаарид “Зөрчлийн хуульд тусгагдсан гүтгэвэл торгох хуулийн заалтыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд эсэргүүцэж буй нь гурван том шалтгаантай. Нэгдүгээрт, торгуулийн хэм хэмжээ эсвэл гүтгэлэгт шийтгэл ногдуулах нь буруу гэж байгаа зүйл бол огт биш. Гүтгэсэн бол хариуцлага тооцох ёстой. Гэхдээ энд ямар асуудал гарч байгаа вэ гэхээр гүтгэлэг гэдэг нэрийн дор үнэн бодитой мэдээлэл өгсөн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид буруутгалд орж, хохирох эрсдэл бий болоод байгаа юм. Хоёрдугаарт, гүтгэлийн хэн, хэрхэн тогтоож хариуцлага тооцох нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, хуульд эрх бүхий албан тушаалтан торгоно гэж заасан байна. Гүтгэлийг нь хэн гүтгэсэн гэж тогтоох вэ. Хариуцлага тооцох эцсийн шийдвэрийг шүүх, цагдаагийн байгууллага тогтоох ёстой байтал хэн нэгэн*

албан тушаалтан, байцаагч нь тогтоогоод хариуцлага тооцож болохгүй. Тухайн хүний өөрийгөө өмгөөлөх эрх нь хязгаарлагдаж байгаа юм. Үүнийг тодорхой болгох хэрэгтэй. Гуравдугаарт, 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль дөрвөн зүйл заалттай. Нэг нь аливаа хэлбэрийн цензурыг хуулиар хориглосон байдаг. Эдийн засаг, улс төрийн болон бусад хэлбэрээр цагдан хорьж болохгүй. Үүний дунд заасан торгууль, шийтгэлийг хуульд суулгаж байна гэдэг өөрөө эдийн засгийн заалт юм. Эдийн засгийн “цензур” хэрэгжинэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл, манайд өнөөдөр дагаж мөрдөж байгаа суурь хуулийг зөрчиж байна” хэмээн байр сууриа илэрхийлсэн юм.

## Д.Амарбаясгалан: Манай намаас МАХН руу ямар шалтгаанаар явах вэ гэдэг чинь сонин шүү дээ

*/МАН-ын Ерөнхий Нарийн бичгийн дарга/ МАН-ын Удирдах Зөвлөл энэ сарын 26-нд хуралдсан. Уг хурлаар ямар асуудлууд хэлэлцсэн талаар МАН-ын Ерөнхий Нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан ярьсан байна. Тэрбээр “Манай намын Удирдах зөвлөлийн хурлаар хэд хэдэн асуудал хэлэлцсэний дотор бага хурлын товьг тогтсон. Тодруулбал, Монгол Улсын 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээ тодруулах бага хурлаа тавдугаар сарын 03-нд хийхээр шийдвэрлэлээ. Бид олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, ард түмний хүсэмжит үлстөрчийг Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэхийн төлөө олон төрлийн судалгаануудыг хийсэн. Тэр ч утгаараа хийсэн судалгаануудаа үндэслэн нэр дэвшигчийн саналыг Удирдах зөвлөл, Бага хуралдаа оруулж, нэр дэвшүүлэх ажиллагааг зохион байгуулла. Монгол Ардын нам 2016 оны УИХ-ын сонгууль болохын өмнө*

Монгол орон даяар, бүх тойрог дээр судалгаа хийж байсан. Тухайн аймагт МАН-аас хэн гэдэг улс төрч нэр дэвшиж, өрсөлдөж ялалт авах боломжтой вэ. Ард түмэнд тэр хүн нь хэр үнэлэгдэж, таалагдаж байна вэ гэдгийг судалсны үндсэн дээр мандатаа хуваарилж, нэр дэвшигчээ тодруулсан. Тэр нь оновчтой байсан гэдэг нь өнөөдөр 65 суудал авчихсан байгаа нь баталгаа байх гэж харж байна. Үүнтэй нэгэн адилаар судалгааныхаа дүнгээ танилцуулж, бага хурлын 310 гишүүн хэнийг дэвших вэ гэдгийг шийднэ дээ. Зөрчлийн хууль нэлээд дуулиан дагуулах шиг боллоо. Мэдээж “Нэг үхрийн эвэр дорговол мянган үхрийн эвэр доргино” гэдэг шиг МАН-ын бүлгийн нэр бүхий гишүүд асуудал оруулаад нөгөөх нь Байнгын хороогоор дэмжигдээд явж байгаа гэдэг нь Монгол Ардын Намтай холбохоос өөр аргагүй. Гэхдээ эрх барьж байгаа намын хувьд энэ хуулийн анхны төсөл нь өргөн баригдахдаа ямар байдлаар орж ирсэн бэ гэдгийг нь хэвлэл мэдээллийнхэн маань, ард иргэд анхаарах хэрэгтэй. Анхнаасаа тийм заалттай байгаагүй. Байнгын хорооны хуралдааны үеэр нэг гишүүнээс санал гарч дэмжигдсэн асуудал байсан. Гэхдээ санал гаргасан гишүүн нь саналаа эргүүлэн татчихсан байна билээ. Мөн нэг зүйл хэлэхэд, манай намаас МАХН руу ямар шалтгаанаар явах вэ гэдэг чинь сонин шүү дээ. О.Баасанхүү гишүүн өглөө босч ирээд л нэг тийм юм ярьдаг жишиг рүү орчихлоо. Яагаад тийм юм яриад байдаг юм бүү мэд. Магадгүй Ерөнхийлөгчийн сонгууль дөхсөнтэй холбоотойгоор өөрийнхөө намын дотоод асуудлыг манай намтай холбож, манай намын нэр дэвшигчийн саналыг багагүй хэмжээгээр хуваалгах хүслээ далд байдлаар илэрхийлж байгаа нь энэ байх гэж харж байна даа. Эрх барьж байгаа 65 суудалтай нам ямар байдгийг манай үлстөрчид мэднэ ээ” хэмээн ярьжээ.

## “Яг түүн шиг” шоу яг цагаа оллоо

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Монгол үзэгчдэд гадны нэвтрүүлгийг орчуулж, эсвэл гадаадын олон ангит кино үзүүлдэг биш Монголдоо бүтээсэн, боловсруулсан олон сайхан нэвтрүүлгийг үзүүлдэг болов. Цаашлаад, телевизийн баг өөрсдөө контент бэлтгэх гэхээс илүүтэй мэргэжлийн студи, агентлагийн үйл ажиллагааг дэмжиж тэдний бүтээлийг худалдаж авдаг болсон нь сайшаалтай. Телевизийн ярилцлага гэхээр нэг хүнийг ширээний ард суулгачихаад ярих гэхээс илүү чөлөөт орчинд чөлөөт байдлаар, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран ярилцаж болдог гэдгийг “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг бидэнд харуулсан, одоо ч харуулсаар байгаа. Цаашлаад хошин шогийн продакшнуудын ганц нэг тоглолтыг өдөр шөнөгүй давтах гэхээс илүү иргэдээ соён гэгээрүүлэх чиглэлд илүүтэй анхаарч, танин мэдэхүйн нэвтрүүлэг хийх болсон нь мөн л нэг том дэвшил. “Боловсрол” суваг телевизийн “80 саяын уналт” нэвтрүүлэг үүний тод жишээ. Монголчууд бид ямархуу авьяастай, чадалтай, бас Монголын урлаг ургын дуу, морин хуур хоёроор дуусахгүй арвин баялаг өв сантай гэдгийг “HD Монгол” телевизийн “Авьяаслаг монголчууд” шоу бидэнд харуулж өгсөн. Тэр нэвтрүүлгээр алс холын Америк, цаашлаад Ази тивийг ч гайхшруулж чадах авьяас байгааг бид олж харсан, бас үзсэн. Хэдэн хувьд аргаар тойруулж, хэрүүл маргаантай хэдхэн солонгос савангийн дууриар тархиа угаалгаж байсан монголчууд маань одоо үздэг нэвтрүүлэг, хүлээдэг, догдолдог шоутай болов. Сүүлийн үед монголчуудыг “Яг түүн шиг” шоу ням гараг бүр эфирийн өмнө уяж болов. Яг л “Халтар царайт” гардаг байсан тэр үе шиг. Өнөөдөр нэвтрүүлгийн оролцогчид хэнийг яаж дуурайх бол хэмээн ням гаргийн орой халуун ам бүлээрээ гэр дүүрэн суугаад нэвтрүүлгээ хүлээдэг болчихож. Амьдралыг арай илүү амттай болгох

зүйлийг тэд үнэхээр хийж байна. Боловсрол суваг телевиз, “Эндемол сайн” группийн албан ёсны эрхтэй “Яг түүн шиг” шоу-г эх орондоо албан ёсны эрхтэй зохион байгуулах болсноор хоёр жил өнгөрөв. Үндсэндээ сүүлийн дөрвөн жил монголчууд хүлээдэг, үзүүлдэг болов. Цаашлаад, телевизийн баг өөрсдөө контент бэлтгэх гэхээс илүүтэй мэргэжлийн студи, агентлагийн үйл ажиллагааг дэмжиж тэдний бүтээлийг худалдаж авдаг болсон нь сайшаалтай. Телевизийн ярилцлага гэхээр нэг хүнийг ширээний ард суулгачихаад ярих гэхээс илүү чөлөөт орчинд чөлөөт байдлаар, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран ярилцаж болдог гэдгийг “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг бидэнд харуулсан, одоо ч харуулсаар байгаа. Цаашлаад хошин шогийн продакшнуудын ганц нэг тоглолтыг өдөр шөнөгүй давтах гэхээс илүү иргэдээ соён гэгээрүүлэх чиглэлд илүүтэй анхаарч, танин мэдэхүйн нэвтрүүлэг хийх болсон нь мөн л нэг том дэвшил. “Боловсрол” суваг телевизийн “80 саяын уналт” нэвтрүүлэг үүний тод жишээ. Монголчууд бид ямархуу авьяастай, чадалтай, бас Монголын урлаг ургын дуу, морин хуур хоёроор дуусахгүй арвин баялаг өв сантай гэдгийг “HD Монгол” телевизийн “Авьяаслаг монголчууд” шоу бидэнд харуулж өгсөн. Тэр нэвтрүүлгээр алс холын Америк, цаашлаад Ази тивийг ч гайхшруулж чадах авьяас байгааг бид олж харсан, бас үзсэн. Хэдэн хувьд аргаар тойруулж, хэрүүл маргаантай хэдхэн солонгос савангийн дууриар тархиа угаалгаж байсан монголчууд маань одоо үздэг нэвтрүүлэг, хүлээдэг, догдолдог шоутай болов. Сүүлийн үед монголчуудыг “Яг түүн шиг” шоу ням гараг бүр эфирийн өмнө уяж болов. Яг л “Халтар царайт” гардаг байсан тэр үе шиг. Өнөөдөр нэвтрүүлгийн оролцогчид хэнийг яаж дуурайх бол хэмээн ням гаргийн орой халуун ам бүлээрээ гэр дүүрэн суугаад нэвтрүүлгээ хүлээдэг болчихож. Амьдралыг арай илүү амттай болгох

## МЭДЭЭЛЭЛ

### Амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны дүнг нэгтгэж байна

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2017 оны нэгдүгээр сарын 16-ны өдрийн А/08 тоот тушаалаар баталсан “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг улсын хэмжээнд зохион байгуулах ажлын удирдамж”-ийн дагуу 330 сум, нийслэлийн 152 хороонд өнгөрсөн гуравдугаар сарын 31-нээс дөрөвдүгээр сарын 09-ний өдрийг хүртэл хугацаанд мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж, улсын хэмжээнд нийт өрхийн 99.5 хувьд буюу 579162 өрхөд хүрч ажилласан байна. Мэдээлэл цуглуулах үед цас зуд, шар усны үед, малын гоц халдварт өвчний улмаас зарим аймгуудад онцгой ноцол байдал үүсч, мэдээлэл цуглуулалтад нөлөөллийн улмаас төлөвлөсөн өрхийг бүрэн хамруулахад хүндрэлтэй байсан. Энэхүү байгалийн хүчин зүйлсээс шалтгаалан мэдээлэл цуглуулалт дууссанаас хойш тав хоног сунгаж, самналт хийх замаар мэдээллийн сан дахь өрхийг бүрэн хэмжээнд хамруулахаар ажилласан. Яг одоо өрхүүдээс авсан мэдээллийг нэгтгэх ажил явагдаж байна. Мэдээлэл цуглуулах ажилд гэрээт тоологч, шивэгч, жолооч зэрэг гэрээт ажилтнаас гадна нийгмийн халамжийн салбарын ажилтнууд болон хөтөч, орон нутгийн төрийн байгууллагын ажилтнууд, удирдлага хяналтын багийнхан зэрэг нийт 7238 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж дуусгалаа. Мэдээллийн сангийн дотоод нийцлийг шалган өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны өрхөөс цуглуулсан мэдээллийн зарим чухал үзүүлэлтүүдийг ижил төрлийн бусад сангуудтай тулган шалгах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд мэдээллийн сан дахь өрхийн гишүүдийн регистерт суурилсан шалгалтыг хийх зорилгоор хамтран ажиллах байгууллагууд болох Үндэсний статистикийн хороо, Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, Зам тээврийн хөгжлийн яам, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газруудад хүсэлтээ хүргүүлээд байна.

# ДЭЛХИЙ

Төгсгөл.  
Түүрч нь I нүүрт

Олон улс судлаачдын зарим нь “Хэрэв Европын Холбооны эсрэг үзэл баримтлал бүхий Марин Ле Пен, Францын Ерөнхийлөгчөөр сонгогдвол хямрал нүүрлэнэ. Харин Э.Макрон тэргүүлбэл “BR-EХП-ийг илүү тайван, тогтвортой замаар шийдэх боломж олдоно” гэж таамаглаж байгаа аж. Хамгийн залуу нэр дэвшигч 39 настай Эммануэль Макрон өмнө нь тус улсын Ерөнхийлөгч Франсуа Олландын удирдлага дор Эдийн засгийн сайдын албыг хашиж байсан туршлагатай төдийгүй, хэрэв Ерөнхийлөгч болбол эдийн засгийн шинэчлэл хийж, нийгэмд

нэрээ дэвшүүлэхдээ боловсруулсан мөрийн хөтөлбөр биеллээ олохын тулд үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай тулгарна. Үүнээс гадна олон нийт ЕХ-нд үлдэх сонголтыг хийсэн тохиолдолд тэрбээр харууцлагаа хүлээн огцрох болно гэдгээ ч зоригтойгоор илэрхийлсэн удаатай. Ле Пенний бас нэг онцлог нь тэрбээр ОХУ-тай ойр харилцаатай байхыг эрхэмлэдэг нэгэн аж. Энэ ч үүднээс ОХУ-ын эсрэг авсан ЕХ-ны хориг арга хэмжээнд шүүмжлэлтэй ханддаг байна. Мөн сонгуулийн өмнө өнгөрсөн сард тэрбээр Москвад айлчилж, Ерөнхийлөгч В.Путинтай уулзалт хийгээд амжсан юм. Харин банкир, Эдийн засгийн сайд асан Эммануэль Макроныг шийдвэрлэх



## Мүүн Жэ Ин шүүмжлэлд өртлөө

БНСУ-ын дараагийн Ерөнхийлөгч болох магадлал хамгийн өндөр гэгдэж буй нэр дэвшигч Мүүн Жэ Ин хэлсэн үгнээсээ үүдэн шүүмжлэлд өртөх болжээ. Тэрбээр энэ сарын 25-нд телевизийн мэтгэлцээнд орох үедээ “Ижил хүйстнүүдэд дургүй” гэж хэлсэн байна. Гэвч түүний энэ үг бэлгийн цөөнхийнхний дургүйцлийг төрүүлж, ижил хүйстний эрхийн хамгаалаа байгууллагаас түүнийг эрс шүүмжлэн, эсэргүүцэж буйгаа илэрхийлсэн байна. Католик шашинд итгэгч Мүүн Жэ Ин харьцангуй либерал үзэл баримтлалтай бөгөөд энэ удаагийн ээлжит бус Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшиж байгаа юм.

Өмнө нь тэрбээр хүний эрхийн хуульч, өмгөөлөгчөөр ажиллаж байжээ. Энэ ч үүднээс либерал үзэлтэй залуус түүнийг түлхүү дэмжиж буй гэнэ. Хамгийн сүүлд буюу тавдугаар сарын 9-нд явуулсан санал асуулгаар гэхэд Мүүн бусад нэр дэвшигчдээ тэргүүлж байсан юм. Гэтэл энэ сарын 25-нд болсон телевизийн мэтгэлцээний үеэр өрсөлдөгч нь түүнээс ижил хүйстний талаархи үзэл бодлыг нь асуужээ. Харин Мүүн ижил хүйстнүүдэд дургүй, тэдний харилцааг ойлгодоггүй гэдгээ илэрхийлээд цаашдаа ч бэлгийн цөөнхийнхний гэрлэлтийг хүлээн зөвшөөрөхгүй гэж ярьсан байна. Гэвэл үүнийг нь эсэргүүцсэн ижил хүйстний эрхийг хамгаалаа байгууллагаас эсэргүүцлийн жагсаал зохион байгуулжээ. Гэвч олон нийтийн талбайд жагсаал цуглаан хийсэн гэх шалтгаанаар тэдний 13 нь баривчлагдсан гэх мэдээлэл байна.

# Эммануэль Макрон / Марин Ле Пен

шударга байдал тогтоохоо амлаад байгаа юм. Харин популист гэгдээд буй Марин Ле Пен “Улсаасаа цагаачдыг гаргаж, хилийн хяналтыг эргүүлэн тогтоон үндэсний аюулгүй байдалд анхаарна” гэдгээ илэрхийлээд байна. Мөн “Исламын шашинтнуудын эсрэг сөрөг хандлагатай гэдгээ удаа дараалан мэдэгдэж, францчуудад давуу эрх олгоно” гэсэн амлалт өгөөд байна. Ингээд дээрх хоёр нэр дэвшигчийн дэвшүүлж буй бодлогыг гурван төрөлд хуваан авч үзье.

### Европ

Үндэсний Фронт намын дарга Ле Пен шийдвэрлэх шатны сонгуульд Эммануэль Макроныг ялсан тохиолдолд Францын гишүүнчлэлийг өөрчлөх талаар ЕХ-ны гишүүн орнуудтай нэн даруй хэлэлцэн гэдгээ илэрхийлсэн. Мөн ЕХ-ны хуулийн дагуу хилийн орчимд байгуулсан аюулгүйн бүсийг чөлөөлнө гэдгээ амлаад буй. Улмаар дээрх амлалтууд биелэхгүй болсон тохиолдолд ЕХ-оос гарах эсэх талаарх бүх нийтийн санал асуулга явуулахаар төлөвлөжээ. “Үндэсний фронт” намын даргын сонгуульд

### Цагаачлал

“Үндэсний фронт” намын дарга Ле Пен хувьд цагаачлалын хатуу бодлого баримтлана гэдгээ тодорхой илэрхийлсэн. Түүний дэвшүүлсэн цагаачлалын бодлого АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трампынхтай төстэй бөгөөд цагаачдын урсгалыг хязгаарлах, албадан гаргах зэрэг заалтууд багтсан байдаг. Ле Пен Ерөнхийлөгчөөр сонгогдсон тохиолдолд хууль бус цагаачдад Францад орогнох газар үлдэхгүйн зэрэгцээ шууд албадан гаргадаг болох гэнэ. Мөн Европын нийт 26 оронд паспортгүй аялахыг зөвшөөрдөг Шенгений

зөвшилцөөс Францыг гаргаж, үндэсний хил хязгаараа сэргээхийг зорьж байна. Өмнө нь “Үндэсний Фронт” намын тэргүүн цагаачдыг хүлээн авах квотыг жилд 10 мянга болгож тогтоох, талаар ярьж байв. Мөн цагаачдад төрийн үйлчилгээг хязгаартай олгох гэнэ.

Гэтэл Эммануэль Макроны цагаачлалын асуудалд баримтлах бодлого нь Марин Ле Пенээс тэс ондоо. Учир нь тэрбээр хэрэв Ерөнхийлөгчөөр сонгогдвол ажлаа авсан эхний зургаан сардаа багтааж, орогнол хүссэн цагаачдыг хүлээн авахаа амласан байдаг. Үүний зэрэгцээ Францыг цагаач, дүрвэгсдийг халуун дотноор хүлээн авдаг улс болгохоо амласан юм. Түүний хувьд хилээ хаахын эсрэг байдаг. Гэхдээ аливаа эрсдэлээс сэргийлэхийн тулд цагаачдын урсгалд хатуу хяналт хэрэгтэй гэж үздэг байна. Э.Макрон Германы канцлер Ангела Меркелийн дүрвэгсдийн хямралын эсрэг арга хэмжээг дэмждэг. Герман иргэний дайны хөлд нэрвэгдсэн Ойрхи Дорнодын орнуудаас ирсэн дүрвэгсдэд хамгийн зөвлөн бодлого баримтлан хүлээн авах болсон бөгөөд Э.Макрон Франц ч гэсэн

түүнээс илүү их зүйл хийх ёстой гэж үздэг ажээ. Мөн Европтой нягт хамтран ажиллаж, цагаачлал, дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх байр суурьтай байдаг байна.

### Эдийн засаг

Ле Пен Ерөнхийлөгч болбол татвараас зугтах явдалтай тэмцэхийн зэрэгцээ дүрэм журмыг хялбаршуулж, цалин бага хар ажилчдын татварыг бууруулаа гэж амлажээ. Мөн франц ажилчдаа ажлын байраар хангасан компаниудад татварын урамшуулал олгож, цагаачдыг ажиллуулж буй компаниудад шинэ төрлийн татвар ногдуулах гэнэ. Үгээр зогсохгүй тэтгэвэрт гарах насыг бууруулан 60 болгож, аль болох олон хүнийг ажлын байраар хангасан компанид аж ахуй нэгжийн цалингийн албан татварыг бууруулах гэх мэтээр 35 цагийн нэмэх саналтай байна. Түүнчлэн тэрбээр ажилгүйдлийн тэтгэмжийг аль болох олон хүнд хүртээх, хувийн бизнес эрхлэгчдэд ч олгохыг хүсчээ. Үүнээс гадна боловсрол гол анхаарлаа хандуулж, сэргээгдэх эрчим хүчинд шилжих шаардлагатайг онцолж байна.

### МЭДЭЭЛЭЛ

## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ИРГЭДЭД ОЙРТОВ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

### Н.БАТЗАЯА

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдөр өчигдөр тохиолоо. Энэхүү өдрийг тохиолдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг өчигдөр Сүхбаатарын талбайд болов. Тус өдөрлөг нь нийслэлийн иргэдэд нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, нийгмийн даатгалын үйлчилгээг нэг дороос үзүүлэн үйл ажиллагаагаа сурталчлан таниулах зорилготой аж. Өдөрлөгт Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний еронхий газрын Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газар, Нийгмийн хамгааллын тусгай төв, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд оролцож, иргэдэд нэг дор үйлчилгээг үзүүллээ. Тухайлбал, ажил хайж буй иргэдийг бүртгэх, нээлттэй ажлын байрыг танилцуулах, тохирох ажлын байранд зуучлах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл хүргэх, ажил мэргэжлийн чиг баримжааны зөвлөгөө өгч ажилласан юм.

Мөн Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой санал, хүсэлт,

өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлах, зөвлөгөө өгөх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих цахим карт олгох зэрэг үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлсэн юм. Түүнчлэн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хууль тогтоомж, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар сурталчлан таниулах, эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээх, зөвлөгөө мэдээлэл өгөх, сайн дурын даатгалын шимтгэл төлөлт, баталгаажуулалт хийх, тэтгэвэр тогтоолт, олголтын талаарх зөвлөгөө өгөх, хөнгөлөлттэй эмийн жороор үйлчлэх гэх мэтчилэн иргэд тэр бүр нэг дор үйлчлүүлж чаддаггүй үйлчилгээг үзүүлэв.

Энэ үеэр иргэд “Өөрсдийн хүссэн мэдээ, мэдээлэл болон үйлчилгээг нэгэн зэрэг авч чадлаа” гэдгийг онцолж байлаа. Иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, төрөөс нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогыг сурталчлах зорилготой тус өдөрлөг жил бүр уламжлал болгон зохион байгуулагддагаараа онцлогтой аж. Өдөрлөгийн үеэр Нийслэлийн халамж үйлчилгээний газрын дэд дарга “Иргэдэд Нийгмийн халамж, үйлчилгээний тухай хуулийг сурталчилж байна. Мөн нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Энэ өдөр нийт 5000 гаруй иргэдэд Нийгмийн халамж, үйлчилгээний тухай хуулийн талаар зөвлөгөө мэдээлэл өглөө. Нийслэлийн төсвийн 30 гаруй хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулагддаг. Энэ жилийн төсөвт ойролцоогоор 101 орчим тэрбум төгрөг тусгагдсан” гэв.

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос дүүргийн нутаг дэвсгэр дэх “УБ-Замын үүд-Чойр чиглэлийн авто замын уулзвараас Очир худалдааны төв хүртэл тарих нарс мод, тулгуур мод, тулгуур мод”-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналын баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50'000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Төрийн сан банк 100200455009 тоот дансанд тушаана.

Үнийн саналыг 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 10.30 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 11.10 цаг-т нээнэ.

### Дотоодын давуу эрх: “Тооцохгүй”

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба.  
Утас:7023-2788

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос дүүргийн нутаг дэвсгэр дэх “Очир худалдааны төвөөс “МТ” шагахуун түгээх станц хүртэл авто замын дагуу тарих гацуур мод, тулгуур мод”-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналын баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50'000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Төрийн сан банк 100200455009 тоот дансанд тушаана.

Үнийн саналыг 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 10.00 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 10.40 цаг-т нээнэ.

### Дотоодын давуу эрх: “Тооцохгүй”

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба.  
Утас:7023-2788

# СПОРТ



ИСПАНИД “БАРСА”, “РЕАЛ”, АНГЛИД “ЧЕЛСИ”, “ТОТТЕНХЭМ” ТҮРҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ ӨРСӨЛДӨЖ БАЙНА

VI нүүрт

МАРИЯ ШАРАПОВА ГЯЛАЛЗАЖ ЭХЭЛЛЭЭ

VIII нүүрт

ЯРИЛЦАХ ЦАГ



**Э.Амарсайхан:**  
 “Оддын хөлбөмбөг”-ийн  
 тоглолтод оролцох багууд  
 таван саяын төлөө  
 өрсөлдөнө

Дэлгэрэнгүй ярилцлагыг VII нүүрт

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

“Сэлэнгэпресс” бүрэлдэхүүнээ зузаатгажээ

Үндэсний дээд лигт арван жил дараалан оролцож буй баг “Сэлэнгэпресс” клуб 2015 онд “Хүрхрээ” нэрээр зохиогдоход “Сэлэнгэпресс” клуб хүрэл медаль хүртэж байв. Харин өнгөрсөн жил зургадугаар байр эзэлсэн билээ. Энэ жил Б.Чин-Оргил дасгалжуулагчийн удирдсан баг өмнөх улирлын байрлалаа урагшуулж,

амжилтаа ахиулахын тулд хүчээ зузаатгажээ. Тодруулбал 2015 оны шилдэг хөлбөмбөгчин, анхны “Алтан бөмбөг”-ийн эзэн О.Баяржаргалыг эгнээндээ элсүүлсэн юм. Түүнчлэн Мизухо Сасаки, Хишида Таку гэсэн үнэнч Япон легионеруудаас гадна арлын улсаас хоёр тоглогч авлаа. Үндэсний дээд лигт 10 дахь улирлаа тоглох

гэж буй “Сэлэнгэпресс” клуб 2008 оноос хойш аваргын цом өргөхийг зорьж буй. Тиймээс энэ жил бүрэлдэхүүнээ улам хүчирхэгжүүлэн, “Хүрхрээ” үндэсний дээд лиг”-ийн шинэ улирлыг эхлүүлэхэд бэлэн болоод байна. Тэдний эхний өрсөлдөгчөөр үндэсний лигийн 10 удаагийн аварга “Эрчим” клуб юм.

Д.Дагвадоржийн авга дүү мэргэжлийн сүмод хүч үзэх нь

Мэргэжлийн сүмогийн их аварга Хакүхо М.Даваажаргал Асапёорюү Д.Дагвадоржийн авга дүүтэй бэлтгэл хийж, зөвлөгөө өгчээ. Тодруулбал, Монгол Улсын манлай заан Д.Долгосүрэнгийн ууган хүү Сугаррагчаагийн хүү Бямбасүрэнтэй 20 орчим минут бэлтгэл хийснийхээ дараа сэтгүүлдэд “Ур чадвартай залуу байна. Мэргэжлийн сүмод орох хүсэлтэй юм билээ. Дэмжиж явна аа” гэжээ. С.Бямбасүрэн эдүгээ Чива мужийн Кашива хотын дунд сургуульд суралцдаг бөгөөд 2015 онд болсон Зүүн Японы аварга шалгаруулах тэмцээнд түрүүлж байжээ. Мөн таван настайгаасаа жүдо, 11-тэйгээсээ чөлөөт бөхийн спортоор хичээллэж байсан гэнэ. Сургуулийнхаа чөлөөт бөхийн багт хичээллэж байсан ч Д.Дагвадорж ахынхаа зөвлөснөөр энэ замыг сонгожээ. Түүний биеийн өндөр 1.84 см бол жин нь 96 кг аж.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “МТ” шатахуун түгээх станцаас 3 дугаар хорооны Дэнжийн гүүр хүртэл тарих шинэ мод, тулгуур мод-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналын баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50'000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Төрийн сан банк 100200455009 тоот дансанд тушаана.

Үнийн саналыг 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 11:00 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 11:40 цаг-т нээнэ.

Дотоодын давуу эрх: “Тооцохгүй”

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно*

Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788

ТЕНДЕРИЙН УРИЛГА

2017 оны 04 дүгээр сарын 28 -нд  
 Тендер шалгаруулалтын нэр:  
 Тендер шалгаруулалтын дугаар: АТҮТ-17/012. БАГЦ 2

Автотээврийн үндэсний төв нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Техникийн хяналтын үзлэгийн явуулын автомашин худалдан авах нийлүүлэх ” тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлийг 50,000 төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:  
 Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 оны аль нэг жилд борлуулалтын хэмжээ 100,0 сая төгрөгөөс доошгүй байх;

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй

байх; Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлэх.

Тендерт оролцогч санал болгож буй тендерийн үнийн дүнгийн

1,5 хувиар тооцож тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10:00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10:30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй Дотоодны давуу эрх тооцохгүй.

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

УБ хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Тээвэрчдийн гудамж, өөрийн байр, Худалдан авалт хариуцсан Мэргэжилтэн Ж.Банзрагч. Утас: 88280448

# СПОРТ

## FOOTBALL NEWS

# ИСПАНИД “БАРСА”, “РЕАЛ”, АНГЛИД “ЧЕЛСИ”, “ТОТТЕНХЭМ” ТҮРҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ ӨРСӨЛДӨЖ БАЙНА



Н.БОЛД

Европын топ таван лиг өндөрлөхөд ердөө 4-5 тойргийн тоглолт үлдээд байгаа билээ. Тэгвэл энэ долоо хоногийн дундуур Испанийн лигийн 34 дүгээр тойргийн тоглолтууд боллоо. Мөн Английн лигт нөхөн тоглолтууд болсон. Энэ хоёр лигт түрүүлэх өрсөлдөөн хамгийн хүчтэй өрнөж байна. Францын лигийн түрүүг “ПСЖ” болон “Монако” багууд ширүүхэн булаалдаж байгааг

бас мартаж болохгүй. Гэхдээ долоо хоногийн дундуур болсноор нь Испани болон Английн лигийг онцолж байна.

“Челси”-д түрүүлэх боломж өндөр байна

Английн хувьд “Челси”-д түрүүлэх магадлал өндөр байгаа. “Челси” клуб өнгөрсөн мягмар гарагийн шөнө талбайдаа “Саутгэмптон”-ыг хүлээж авч, 4:2-оор буулгаж авсан

билээ. Ингэснээр 78 оноотой болж, тэргүүлээ хадгалсан. Тоглолтын тав дахь минутад Азар тооны харьцааг нээсэн. Харин 24 дэх минутад Ромеу тэнцүүлсэн. Гэвч 45 дахь минутад Гарри Кейхилл багтаа тэргүүлэл авчирсан. Улмаар 53, 89 дэх минутад Диего Коста хоёрыг оруулж, премьер лигт 19 гоолтой болжирлээ. Тоглолтын 90 дэх минутад зочин багаас Бертран нэг гоол нэмснийг эс тооцвол “Челси” бүрэн утгаараа илүү байсан юм. Тэгвэл Лондоны “Цэнхэрүүд”-тэй хамгийн ойрхон өрсөлдөж буй “Тоттенхэм” өнгөрсөн лхагва гарагийн шөнө “Кристал Палас”-ын талбайд зочилж, 0:1-ээр буулгаж авсан. Ингэснээр “Челси”-тэй түрүүлэх өрсөлдөөнд хэвээр үлдлээ. Хоёр багийн хооронд ердөө л дөрвөн онооны зөрүү бий. Мөн хоёр баг хоёулаа 33 тойргийн тоглолт хийсэн. Үлдсэн таван тоглолтод асуудал шийдэгдэнэ. “Челси”-гийн хувьд 35 дугаар тойрогт “Эвертон”-тай үзэх бол “Уотфорд”-той нөхөн тоглолт

хийнэ. 336 дугаар тойрогт “Миддлсбро”-г талбайдаа хүлээж авах бол 37 дугаар тойрогт “Вест Бромвич”-ын талбайд зочилж, улирлын сүүлийн тоглолтоо “Сандерланд”-тай хийнэ. Ганц оноо алдаж магадгүй гэж тооцохоор тоглолт нь “Эвертон”-ы талбай байж магадгүй. Бусад тоглолтод нь “Челси” ерөнхийдөө бүтэн оноогоо аваад гарчих байх. Гэхдээ бөмбөг бөөрөнхий, премьер лиг бол премьер лиг. “Тоттенхэм”-ийн хувьд 35 дугаар тойрогт талбайдаа “Арсенал”-тай тоглоно. Оноо алдах магадлал нэлээд өндөр. Хэрвээ энэ тоглолтод тэнцэх юм уу хожигдвоо түрүүлэх өрсөлдөөн шууд утгаараа дуусна. Цаашлаад “Лестер”-ийн талбайд зочилоо. Бас л эрсдэл өндөртэй тоглолт. 36 дугаар тойрогт “Вест Хэм”-ийн талбайд зочлох учиртай. Мөн л эвгүй өрсөлдөгч. 37 дугаар тойрогт талбайдаа “Манчестер Юнайтед”-ыг хүлээж авна. Энэ бүх тоглолтод тэд хожиж байж л түрүүлэх өрсөлдөөндөө байх юм. Гэхдээ дэндүү хүнд хуваарьтай байна. 38 дугаар тойрогт “Халл”-ын талбайд зочлох тоглолт л арай гайгүй. Гэхдээ л “Халл” талбайдаа тунхүчтэй. Тиймээс “Челси” түрүүлэх нь тодорхой болчихлоо.

“Реал” уу, “Барса” юу

Испанийн Ла лигийн 34 дүгээр тойргийн тоглолтууд өнгөрсөн өдрүүдэд боллоо. Тэр дундаа лхагва гарагийн шөнө түрүүлэх өрсөлдөөн хүчтэй өрнүүлж буй “Реал” болон “Барселона” клубүүд тоглож, өрсөлдөгчөө бүтниргэсэн. Хүснэгтийг тэргүүлэгч “Барселона” клуб талбайдаа “Осауна”-г хүлээж авч, 7:1-ээр буулгаж авсан юм. Ингэснээр 78 оноотой болж, тэргүүн байраа хадгаллаа.

Тоглолтын 12, 61 дэх минутад Месси дубль хийж, Ла лигийн 33 дахь гоолоо оруулсан. Түүний араас Андре Гомеш 30, 57 дахь минутад

хоёрыг хийсэн бол 64, 86 дахь минутад Пако Алькасер дубль хийж. Харин Машерано 67 дахь минутад торгуулийн цохилтоос “Барса”-гийн төлөө анхны гоолоо оруулжээ. Зочин багаас нэр төрийн ганц гоолыг 48 дахь минутад Роберто Торрес оруулсан байна. Тэгвэл хүснэгтийн хоёрдугаар байрт бичигдэж буй “Реал Мадрид” клуб “Департиво”-гийн талбайд зочилж, 2:6-аар бутниргэлээ. Ингэснээр 78 оноотой болж, гоолын зөрүүгээр хоёрдугаар байрт бичигдэж байна. “Барса” аль хэдийнэ 101 гоол оруулсан бол “Реал” 90-ийг оруулсан. Алдсан гоолоороо ч “Барса” клуб “Реал”-аас бага байгаа. Өөрөөр хэлбэл, “Барса” 33 гоол алдсан бол “Реал” 38-ыг. Гэхдээ “Реал”-ын халаасанд нэг тоглолт үлдсэн нь тэднийг арай уужруулж байгаа билээ. Тоглолтын нэг дэх минутад тооны харьцааг нээсэн. Улмаар зочин багаас Хамес 14, 66 дахь минутад дубль хийсэн бол Васкес 44 дэх минутад нэгийг нэмж. Мөн 77 дахь минутад Иско жижүүрийн нэг гоол нэмэрсэн бол өмнөх тойрогт “Барса”-гийн эсрэг гоол оруулсан Каземиро 87 дахь минутад гүйцээжээ. Эзэн багаас Андоне 37, Хоселу 84 дэх минутад нэг нэг гоол оруулсан байна. Одоо “Реал”-д тав, “Барса”-д дөрвөн тоглолт дутуу байгаа. Хэрвээ хоёр баг үлдсэн тоглолтуудад бүдрэхгүй бол “Реал” түрүүлнэ. Мадрид хотын багийн хувьд 35 дугаар тойрогт талбайдаа “Валенсиа”-тай тулах бол 36 дугаар тойрогт “Гранада”-гийн талбайд зочлох учиртай. Тэгвэл 37 дугаар тойрогт талбайдаа “Севилья”-тай тулах бол 38 дугаар тойрогт “Малага”-гийн талбайд зочилоо. Ерөнхийдөө хүндхэн тоглолтууд хийхээр байна. “Барса”-д бол “Эспаньол”, “Вильярреал”, “Лас-Пальмас”, “Эйбар” гэсэн учраа л байгаа. Ерөнхийдөө гайгүй. Бүгдэд нь хожих байх. Тэгэхээр “Реал” үлдсэн бүх тоглолтодоо хожиж байж л түрүүлэх нь.

## “Боруссия Дортмунд” финалд үлдлээ

Германы цомын тэмцээний хагас шигшээ шатны хоёр дахь тоглолт өнгөрсөн лхагва гарагийн шөнө боллоо. Энэ шатанд Германы хоёр том баг болох “Байерн Мюнхэн” болон “Боруссия Дортмунд” клубүүд хоорондоо учраа таарсан. Мюнхэн хотод болсон энэ тоглолтод Дортмундын баг өрсөлдөгчөө 2:3-аар буулгаж авсан юм. Ингэснээр “Айнтрахт”-тай түрүү байр булаалдахаар болж байгаа юм. Тоглолтын 19 дэх минутад Марка Ройс тооны харьцааг нээсэн бол Мартинес 28 дахь минутад хариуг нь барьжээ. Улмаар 41 дэх минутад Хуммельс “Байерн”-д тэргүүлэл авчирсан байна. Гэвч Обамеянг 69 дэх минутад тэнцүүлж, Дембеле 74 дэх минутад багтаа ялалт авчирсан гоолыг оруулжээ. Ийнхүү “Боруссия Дортмунд” лигийн хамгийн хүчтэй өрсөлдөгчөө буулган авч, финалд үлдлээ.



## №24 Дундаж наслалт ба дундаж амьдрах хугацаа гэж юу вэ

Манай сонин долоо хоног бүрийн баасан гарагт нийгмийн даатгалын үйлчилгээ, түүний талаархи түгээмэл асуулт хариултын буланг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын Монгол Улсад хэрэгжүүлж буй Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн мэргэжилтнүүдтэй хамтран бэлтгэн хүргэж байгаа билээ. Ушигчдын төдийлөн мэддэггүй ч, заавал мэдэж байх ёстой, мөн манай улсын тэтгэврийн тоетолоонд нутагшуулж болохуйц түгээмэл асуултад Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн ахлах зөвлөх Ямашита Мамору хариулж байна.

-Монголын статистик мэдээллээс харахад монгол эрэгтэй хүний дундаж наслалт 66 байна. Жишээ нь, 60 настай эрэгтэй дунджаар зургаан жил л амьдарна гэсэн үг үү?


-Монгол эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66, эмэгтэйчүүдийнх 76 байгаа. Тэгвэл одоо 60 настай эрэгтэй, цаашид дунджаар зургаан жил амьдарна гэж ойлгох нь буруу юм. Яагаад гэдгийг одоо тайлбарлая.

Эхлээд дундаж наслалтыг тайлбарлах нь зүйтэй болов уу. Энэ нь Монголд байгаа бүх насны иргэдээс дараа жил нь хэдэн хүн амьд үлдэх вэ гэсэн хувиас тооцон гаргадаг үзүүлэлт юм. Дөнгөж төрсөн хүүхдийн нэг ой хүртлээ амьд байх хувь, нэг настай хүүхэд хоёр нас хүртлээ амьд байх хувь гэх мэтчилэн нас тутмаар амьд байх хувийг тооцож, бүх насныхны амьд байх хувийг нэмээд дундажлаж гаргасан утгыг дундаж наслалт гэнэ.

Тэгвэл 60 настай эрэгтэй дунджаар хэдэн жил амьдрах вэ гэдгийг дээрх тооцоолоос арай өөрөөр тооцно. Дундаж наслалт гэдэг нийт насыг хэлж байгаа бол 60 настай эрэгтэйн дундаж амьдрах хугацааг тооцохдоо 60 наснаас дээш эрэгтэйчүүдийн амьд үлдэх хувийг тооцно. Өөрөөр хэлбэл, 60 настай эрэгтэй 61 нас хүртэл амьд байх хувь, 61 настай эрэгтэй 62 нас хүртэл амьд байх хувь гэх мэтчилэн

### Дундаж амьдрах хугацааны тооцоолол (80 настай, эм)

80 настай эмэгтэйн дундаж амьдрах хугацаа = 80 наснаас хойш үргэлжлэн амьдрах хүн жилийн ийлбэр / 80 настай эмэгтэйчүүдийн тоо



60-аас дээш насны эрэгтэйчүүдийн амьд байх хувийг нэмж, дундаж утгыг тооцох бөгөөд энэ нь 60 настай эрэгтэй дунджаар цаашид хэдэн жил амьдрах вэ гэдгийг илэрхийлнэ. 60 настай хүн хэдийнээ нярай үеэ, 20 нас, 40 насныг насласан учраас мэдээж энэ хүртэлх насны амьд үлдэх хувь тооцоонд хамааралгүй гэдгийг та бүхэн ойлгож байгаа биз ээ.

Ингээд 60 настай эрэгтэй цаашид дунджаар хэдэн жил амьдрах вэ гэхээр монгол эрэгтэй хүний дундаж наслалт 66 наснаас өндөр байх юм. Дундаж наслалт гэдэг нярайн эндэгдэл өвчлөл, залуу үед тохиолдол эрсдэл авто тээврийн осол гэх мэт эергийг харгалзан тооцдог тул богино байх нь аргагүй билээ. Иймд 60 настай эрэгтэй дунджаар цаашид хэдэн жил амьдрах вэ гэдэг тоон утгыг гаргахдаа дээрх эндэгдэл, эрсдлийг хасч, зөвхөн 60-аас дээш насны өндөр настай эрэгтэйчүүдийн амьд үлдэх хувийг тооцдог болохоор арай илүү өндөр тоо гарна. Үүнийг 60 настай эрэгтэй хүний “дундаж амьдрах хугацаа” гэнэ.

Монголд тэтгэвэрт гарах насны хүмүүсийн дундаж амьдрах хугацааг харвал 60 настай эрэгтэй ойролцоогоор 16 жил 76 нас, 55 настай эмэгтэй ойролцоогоор 24 жил 79 нас байгаа бөгөөд энэ нь дундаж наслалтаас илүү өндөр байдаг байна.

Дээрх тайлбараас та бүхэн дундаж наслалт бөгөөд дундаж амьдрах хугацааны ялгааг ойлгосон байх гэж найдаж байна.



## ЧИНГИС ХААН БАНК

### САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

/Сая төгрөгөөр/

Table with columns: Хөрөнгө, Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, Хөрөнгө оруулалт, Зээл (цэвэр дүнгээр), Хэвийн зээл, Чанаргүй зээл, Зээлийн хойшлогдсон төлбөр, Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, Зээлийн эрсдэлийн сан, Дериатив санхүүгийн хөрөнгө, Бусад санхүүгийн хөрөнгө, Бусад санхүүгийн бус хөрөнгө, Үндсэн хөрөнгө, Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, Борлуулгах зориулалттай хөрөнгө, Биег бус хөрөнгө, Нийт хөрөнгийн дүн, ӨР ТӨЛБӨР, Харилцахад төлсөн хүү, Хадгаламж, Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, Бусад эх үүсвэр, Бусад өр төлбөр, Нийт өр төлбөрийн дүн, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, Хувь нийлүүлсэн хөрөнгө, Нэмж төлөгдсөн капитал, Халаасны хувьцаа, Дахин үнэлгээний нэмэгдэл, Хуримтлагдсан ашиг, алдагдал, Бусад өөрийн хөрөнгө, Өөрийн хөрөнгийн дүн, Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн, Тэнцлийн гадуурх данс, Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр)

### МОНГОЛ БАНКНААС ТОГТООСОН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУРУУЗҮҮЛЭЛТИЙН

Table with columns: Зохиистой харьцааны шалгуур үзүүлэлт, Байвал зохих, Биелэлт. Rows include: Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр, Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын хөрөнгө, Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт, Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн, Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн.

### ОРЛОГЫН ТАЙЛАН

/Сая төгрөгөөр/

Table with columns: Орлого, зардлын зүйл, Хүүгийн орлого, Монголбанкинд байршуулсан хөрөнгийн, Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан, Үнэт цаасны, Зээлийн, Бусад хүүгийн орлого, Хүүгийн зардал, Харилцахад төлсөн хүү, Хадгаламжинд төлсөн хүү, Зээлийн хүүгийн зардал, Үнэт цаасны хүүгийн зардал, Бусад хүүгийн зардал, Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)], Эрсдэлийн сангийн зардал, Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)], Бусад орлого, Хүүгийн бус орлого, Арилжааны орлого, Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого, Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, Бусад хүүгийн бус орлого, Бусад орлого, олз, Бусад зардал, Хүүгийн бус зардал, Бусад эрсдэлийн сангийн зардал, Арилжааны зардал, Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал, Хураамж, шимтгэлийн зардал, Үйл ажиллагааны бусад зардал, Бусад зардал, гэрз, Татварын өмнөх ашиг, алдагдал [(5)+(6)-(7)], Орлогын татварын зардал, Татварын дараах ашиг, алдагдал [(8)-(9)], Бусад орлого, Тайлант хугацааны нийт орлогын дүн [(10)+(11)]

# СПОРТ

## ЯРИЛЦАХ ЦАГ

### Н.ПУНЦАГБОЛД

Монголын Хөлбөмбөгийн холбоо, "Арвайн үндэс" ХК-тай хамтран гурав дахь жилдээ зохион байгуулж буй "Хүрхрээ үндэсний дээд лиг"-ийн нээлттэй үйл ажиллагаанд зориулсан "Оддын хөлбөмбөг"-ийн тоглолт маргааш 14:00 цагт эхлэх билээ. Энэхүү тоглолт болон хөлбөмбөгийн лигийн тэмцээний талаар Монголын Хөлбөмбөгийн холбооны Маркетингийн албаны дарга Э.Амарсайхантай ярилцлаа.

**-Монголын Хөлбөмбөгийн холбооноос "Оддын хөлбөмбөг"-ийн тоглолтыг зохион байгуулах гэж байна. Энэхүү тоглолтын талаар мэдээлэл өгөөч?**

-Монголын Хөлбөмбөгийн холбоо "Арвайн үндэс" компанитай гэрээ байгуулж, гурав дахь жилдээ



# Э.Амарсайхан:

## "ОДДЫН ХӨЛБӨМБӨГ" - ИЙН ТОГЛОЛТОД ОРОЛЦОХ БАГУУД ТАВАН САЯЫН ТӨЛӨӨ ӨРСӨЛДӨНӨ

хамтран ажиллаж байна. Дөрвөн жилийн 500 сая төгрөгийн буюу их хэмжээний мөнгөн дүнтэй гэрээ байгуулсныг та бүхэн мэдэж байгаа байх. Энэ жилийн "Хүрхрээ" дээд лигийн шагналын сан 120 сая төгрөг болж өссөн. Цагийн хувьд бага зэрэг өөрчлөлт орсон. Бямба, ням гарагуудад 13:00, 16:00, баасан гарагийн орой 19:00 цагаас тоглолтууд болно. Долоо хоногтоо гурван өдөр тоглолт болно. Уламжлал ёсоор NTV телевизээр шууд дамжуулна. Бямба гарагийн нээлттэй тоглолтын өмнө 14:00 цагаас "Оддын хөлбөмбөг"-ийн тоглолтыг зохион байгуулах юм. Урлаг, спортын олын танил хүмүүс Монголын хөлбөмбөгийг хүүхэд, залуучуудад сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, цаашлаад нийгмийн харилцангалын үүднээс аутизмыг таниулах нэг сарын аяныг дэмжиж энэхүү тоглолтод оролцож байгаа юм. Мөн Монголын хөлбөмбөгийн төлөө нэгэн дуугаар "За" гэж дуугарч байна. "Оддын хөлбөмбөг"-т оролцох олны танил, нэртэй жүжигчин, дуучин, спортын тамирчдад Монголын Хөлбөмбөгийн холбооны Ерөнхийлөгч А.Ганбаатар өөрийн гарын үсэгтэй урилгыг гардуулсан. Урилга гардуулах үйл ажиллагаа сүүлийн долоо хоногийн турш болсон. Цаашдаа "Оддын хөлбөмбөг"-ийг жил бүр зохион байгуулахаар төлөвлөж байна. Магадгүй намар "Хүрхрээ" дээд лиг өндөрлөхтэй зэрэгцээд энэ тоглолтыг дахин зохион байгуулахаар ярьж байгаа. "Оддын хөлбөмбөг"-ийн тэмцээнд оролцох "Цагаан барц" болон "Хөх чононууд" баг таван сая төгрөгийн төлөө өрсөлдөнө. Эхний гоолын эзнийг 500 мянган төгрөгөөр урамшуулахаар болсон. Тоглолтыг илүү сонирхолтой, өрсөлдөөнтэй болгох үүднээс ийм урамшуулал олгохоор шийдсэн. "Оддын хөлбөмбөг"-ийн тасалбар 3000

төгрөгийн үнэтэй. Энэ мөнгөний 1000 төгрөг тутам нь аутизмтай хүүхдүүдийн сайн сайхны төлөө зарцуулагдана. **"Оддын хөлбөмбөг"-ийн тоглолтод оролцох олны танил эрхмүүдийг хэрхэн сонгосон юм бэ. Мэдээж хөлбөмбөгт дуртай, дэргтэй хүмүүсийг сонгосон биз дээ?** -Мэдээж хөлбөмбөгтэй ямар нэг байдлаар холбоотой хүмүүсийг сонгосон. Гадаадын хөлбөмбөгийг үзэж, дэмждэг хөгжөөн дэмжигчид их байна. Тэр дундаа "Челси"-г дэмждэг 5-6 хүн орон гэж байгаа. Түүнээс гадна Испанийн "Барселона" клубыг дэмждэг гурван олны танил эрхэм оролдоно. Цаашлаад Италийн "Рома", "Интер", "Милан", Английн "Арсенал" клубыг дэмждэг хөгжөөн дэмжигчид байгаа. Түүнээс гадна хөлбөмбөгийг идэвхтэй тоглодог, чөлөөт цагаа хөлбөмбөгт зориулдаг хүмүүс ч бий. Жишээлбэл, жүжигчин Х.Манлайбаатар, Б.Батбаяа гээд олон хүнийг нэрлэж болно. Хөлбөмбөгийн талаар мэдлэгтэй, тайлбарлаж явсан хүмүүс ч бий. Хоёр багийг олимпийн аваргууд ахална. "Хөх чононууд" багийг Э.Бадар-Ууган, "Цагаан барсууд" багийг Н.Түвшинбаяр ахлаж талбайд гарна. Тэдний араас Үндэсний бөхийн улсын арслангууд нэг нэг багт хуваарилагдсан. Тухайлбал, Улсын арслан Н.Батсуурь, Р.Пүрэвдагва нар оролцоно. Мөн тулааны тамирчин Ж.Нарантунгалаг, Ц.Амарсайхан буюу Шинобу Амарая нар хоёр багт нэг нэгээрээ багтаж байгаа. Цаашлаад жүдо, чөлөөт бөхийн тамирчид, соёл урлагийнхан оролдоно. Нэлээд сонирхолтой бүрэлдэхүүн гарсан гэж хэлж болно. "Хөх чононууд" багийг Ш.Гүрбазар дасгалжуулагч Нөгөө багийн дасгалжуулагч хараахан тодроогүй байна. Хоёр хүнд санал

тавьсан. СГЗ Г.Золжаргал, МҮОХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга байсан Д.Отгонцагаан гэсэн хоёр хүнд санал тавьсан. **-Хэдэн минут тоглох вэ?** -Талдаа 20 минутаар хоёр үе тоглоно. Бооцоо таван сая төгрөг. Үүнээс үүдээд хоёр багийн өрсөлдөөн аль хэдийнэ эхэлсэн. Сошиал ертөнцөөр нэгэн рүүгээ сэтгэл зүйн дайралт хийх, ёжлох зэрэг ажиллагаа аль хэдийнэ эхэлсэн байсан. **"Оддын хөлбөмбөг"-ийг зохион байгуулж байгаа гол зорилго нь юу вэ. Мэдээж аутизмын эсрэг үйл ажиллагааг дэмжинэ гэж байсан. Түүнээс гадна?** -Үндсэн зорилго бол Монголын хөлбөмбөгт үзэгчдийг татах, сонирхолтой болгох юм. Энэ тэмцээнд оролцох олны танил хүмүүс Монголын хөлбөмбөгийг илүү их сонирхолтой болгох, сүүлийн 2, 3 жилийн хугацаанд гарсан үрсрэнгүй хөгжлийг таниулах, хөлбөмбөгөөр монголчууд цаашаа явах боломжтой гэдгийг мэдрүүлэх гэсэн юм. Тиймээс л цэнгэлдэхэд үзэгчдийг татах үүднээс энэхүү үйл ажиллагааг зохион байгуулж байна. Гэхдээ энэ хүмүүс бооцоо гаргаад, зүгээр нэг хөлбөмбөг тоглоод, мөнгө төгрөг олохдоо биш. Дэлхийн нийтийн жишиг байдаг. Нийгмийн харилцаагаа дэмжиж, үйл ажиллагаа зохион байгуулдаг. Энэ сард бол аутизмыг таниулах аян явагдаж байгаа. Энэ аян маргааш өндөрлөж байгаа юм билээ. Яг тэр өдөр нь бид "Монгол аутизм" ТББ-тай хамтраад, дэмжиж ажиллаж байна. **-Минут нь арай цөөн биш үү. Хэтэрхий хурдан дуусчихгүй юу?** -Яг спортоор хичээллэдэггүй хүмүүс болохоор хэцүү шүү дээ. Тэгээд ч стандарт хэмжээтэй, том талбайд тоглохоор бүр хэцүү. Тэгээд ч талдаа 20 минут гэдэг чинь

ахмадуудын тоглодог цаг. Манай соёл урлагийнхан сэтгэл гаргаад, за гээд дэмжиж байгаа боловч халуунд, том талбайд 20 минут тасралтгүй гүйнэ гэдэг бол хэцүү. Тийм болохоор багадаагүй байх. Түүнээс гадна хүмүүс урлагийнхан спортынхны эсрэг тоглоно гэж ойлгоод байх шиг байна. Холлидоно. Хэдийгээр хөлбөмбөгийнх биш ч гэсэн жүдо, чөлөөт гээд байнга спортоор хичээллэдэг, бэлтгэлтэй гэдэг утгаараа урлагийнхантай тоглолт тэнцвэр нь алдагдана. Манай урлагийнхан чинь хэдийгээр хөлбөмбөгийг сонирхдог ч гэсэн тоглож үзээгүй. Зарим нь жингийн илүүдэлтэй шүү дээ. Тийм болохоор хэцүү. **-Зөвхөн хөлбөмбөг тоглоод өнгөрөхийг үзэгчдэд зориулсан өөр үйл ажиллагаа байгаа биз дээ?** -Оролцож буй 32 тоглогч өөрийнхөө гарын үсэгтэй бөмбөгийг үзэгчдэд тараана. Тоглолтын дараа оролцогчидтой чөлөөтэй уулзаж, зургаа авахуулна. Сүүлийн үед "Яг түүн шиг" шоунд оролцож, үзэгчдийг байлдан дагуулж байгаа урлагийнхан оролдоно. Үндэсний бөхийн арслангууд, Олимпийн аваргууд байна. Ийм хүмүүстэй гар барьж үзэх, зургаа авахуулыг хүсч буй хүүхэд, залуучууд зөндөө байгаа байх. Тэдэнд боломж гарч байна гэсэн үг. **-Монголын хөлбөмбөгийн лиг хөгжиж, дэвшиж л байна. Мэдээж үзэгчид бага байгаа нь ойлгомжтой. Гэхдээ сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа болов уу?** -Жил жилээр нэмэгдсээр байгаа. "Хүрхрээ үндэсний дээд лиг" гэдэг нэртэй болсноор гурав дахь жилдээ л ороож байна. Эхний жилдээ хөлбөмбөгийн лигийг үнэгүй үзүүлж байсан. Түүрүү жилээс 2000 төгрөгөөр зарж эхэлсэн. Ингэсээр 11 сая төгрөгийн орлоготой ажилласан. Энэ мөнгөө эргүүлээд

4-10 дугаар байрт орсон багууддаа шагналмаагаар өгсөн. Зорилго нь юу вэ гэхээр, багуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх. Дөрөвдүгээр байрт орсон баг долдугаарт жагссан багаас 1.5 саяар илүү мөнгө авах жишээтэй. Энэ бол өрсөлдөөнийг сүүдлийн тойрог хүртэл хадгалах зорилготой. Тэгээд ч энэ жил шагналын сан 120 сая төгрөг болж өссөн. Одоогоор дээд лигт 10, доод лигт 10 баг тоглож байна. Доод лигтээс шалгарсан "Атлетик 220", "Тоёо" багууд дээшээ гарна. Харин дээд лигтээс мултарсан хоёр баг доошоо орно. **-Энэ жил 40-өөд легионер тоглогч Монголд ирж тоглоно гэсэн. Энэ талаар мэдээлэл өгөөч?** -Дэлхийн 11 орны 39 легионер тоглогч ирж, 10 багт тоглоно. Уламжлал ёсоор Африкийн улсуудаас ирж байгаа. Япон, Солонгосоос тамирчин ирнэ. Энэ жил Ардчилсан Солонгосоос тамирчин ирж байгаа нь нэлээд нөлөө үзүүлэх байх. Хойд Америкаас Канад, Америкийн тоглогчид ирж байна. Европоос гэвэл Серби улсаас ирж буй тамирчдын цуваа улам л нэмэгдэж байгаа. Багуудыг дэмжиж байгаа юу. Эсвэл багийн эзэд өөрсдөө авчирч байгаа юу? -Дэлхийн нийтэд жишиг байдаг. Хөлбөмбөг тэмцээн зохион байгуулах, дүрэм журмаа харууцана, барина. Нөөц бололцоогоор хангана. Талбай, шүүгч болоод бусад зүйлээр хангана гэсэн үг. Харин клубууд

өөрсдөө тамирчнаа авчирна. Дэлхий нийтэд ч тийм байгаа. Ямар тамирчин, хаанаас авах вэ гэдгээ өөрсдөө шийднэ. Хамгийн гол нь стандартын дагуу л ажиллах ёстой. Агентар дамжуулж, клубээс клубын хооронд гэрээний дагуу авах ёстой шүү дээ. Тэр журмаар л явж байгаа. **-Та спортын сэтгүүлч хүн. Тэр дундаа хөлбөмбөгтэй нэлээд ойр. Одоо холбоонд ажиллаж байна. Тэгвэл манай хөлбөмбөгийн тамирчдын үр чадвар хэр дээшилж байна вэ?** -Улам л дээшилж байна. Үүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байгаа. Лиг сүүлийн гурван жилд өөрчлөгдсөө. Өмнө нь ажлын өдрүүдээр лигийн тэмцээн болдог байсан. Одоо болохоор амралтын өдрүүдээр зохион байгуулдаг болсон. Учир нь манай тамирчид чинь өөр ажилтай шүү дээ. Дан ганц хөлбөмбөгөөр хоолоо олж идэхгүй. Тийм болохоор амралтын өдрөөр тоглох боломжуудыг нээгээд өгчихлөө. Мөн олон нийтэд хөлбөмбөгийн тэмцээнээ хүргэе гээд телевизээр шууд цацаад эхэллээ. Дээрээс нь шагналын санг нэмчихлээ. Түүнийгээ дагаад клубүүдийн тэмцээнд оролцох ашиг сонирхол нь нэмэгдсэн. 120 сая төгрөгийн шагналын сантай тэмцээнд оролцож байгаа баг зарчруулах эмжээний хөрөнгө мөнгө хэчнээн хэмжээ вэ. Түүрүүдэд 30, 40 сая төгрөгийн шагнал авахын төлөө юу хийх вэ. Хэдэн тамирчин гаднаас авах вэ гэх зэргээр боломж нээгдэнэ. Цаашлаад дотоодын тамирчдын үнэ ч гэсэн нэмэгдэнэ. Тухайлбал, нэг багаас ур чадвар сайтай тамирчныг таван сая төгрөгөөр авах жишээтэй. Улмаар нөгөө тамирчиндаа нэг жил тоглосных нь төлөө автомашин өгөхөөр тохиролцож байгаа юм. Энэ мэтээр ханш тогтоод эхэлчихсэн. Монголын шилдэг тамирчид болох Төрбат, Наранболд гэхэд шинэ багтайгаа улирлын таван сая төгрөгийн гэрээ байгуулах жишээтэй. 5-6 сар тоглоод л авах мөнгө. Мэргэжлийн хөлбөмбөгийн лигтэй болох эхлэл тавигдаад л байна. Дээрээс нь энэ боломжийг хангахын тулд холбоо зөв менежменттэй ажиллах зэрэгтэй. Амралтын өдрүүдээр тэмцээн зохион байгуулах ч гэдэг юм уу. **-Манай лигт хамгийн үнэтэй тамирчин хэдэн төгрөгөөр зарагдаж байна вэ?** -3.5 сая төгрөгөөр л наймаа хийж байна. Шигшээ багийн шилдэг довтлогч, хамгаалагч нарын наймаа энэ үнийн дүнд хүрдэг. Тэгэхдээ зарим тамирчныг худалдаж авсан үнийг ил тод зарлахгүй тохиолдол ч байна. Гэхдээ хэйн тамирчин автомашин үнэ хүртээд, цаашлаад өөрөө машин авах гэрээ хийж байна гэдэг бол өмнө нь байгаагүй л дэвшил шүү дээ. Цаашлаад Монголын хөлбөмбөг илүү хөгжинө. Африкаас, Ардчилсан Солонгосоос тамирчид ирж байна. Тэднийг чинь зүгээр л хүнд үзүүлэх гэж авчиргаагүй. Эцсийн эцэст багаа сайжруулж, цом авах гэж, өндөр шагналтай байранд шалгаргахын төлөө л тэмцэж байгаа байхгүй юу.

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

- [Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар]нь [Дулааны станцийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах]-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээг үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлж ирүүлэхийг урьж байна.
  - Энэхүү зөвлөх үйлчилгээ нь [Дулааны станцийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, 2017-3У008, Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар, 5 сарын хугацаанд багтаан гүйцэтгэх] болно.
  - Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Тийм
- БХБЯмаанаас олгосон дараах зөвшөөрөлтэй байх
- 1.3.1. Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг
- ЭХЯмаанаас олгосон дараах зөвшөөрөлтэй байх
- 03.9.5. 0.7-40.0-өөс доош кг/см<sup>2</sup> даралттай зуухны ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах
4. Мэдүүлэг ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартай нотлох мэдээллийг (ГБОНХБАУХАТХуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгууруудыг хангаж буйг нотлох баримт бичгийг) ирүүлнэ. Үүнд:
    - Байгуулагын ерөнхий танилцуулга
    - Байгуулагын гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан байна/
    - Тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байна
    - Сүүлийн 3 жилд /2014, 2015, 2016/ гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлага
    - Сүүлийн 3 жилийн /2014, 2015, 2016/ аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан
    - Зөвлөх хуулийн этгээдийн ажиллах боловсон хүчин чадварын талаарх мэдээлэл /Голлох инженер, техникийн ажилчдын ур чадварын мэдээлэл, туршлага, зэргийн үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар, гэрээт ажилтан бол ажлын гэрээг хавсаргах/ ирүүлэх
    - 5. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно. Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендер оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэгээр нэвтрэн орж тендерийн материалгаа цахим хэлбэрээр ирүүлнэ.
    - 6. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг [2017.04.28-2017.05.05]-ний [08:00-17:00] хооронд авч болох бөгөөд мэдүүлэг дор дурдсан хаагаар [2017 оны 05 сарын 05-ны өдрийн 17:00 минут]-ийн дотор ирүүлнэ үү.

[Сүхбаатар аймаг "Орон нутгийн өмчийн газар" /Баруун-Урт сум 7-р баг нутгийн удирдлагын ордон 3 давхарт 306 тоот өрөө, Утас : 70518123, С.Баярмаа 99044893/

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

- 2017.04.28.
- [Байгаль орчин, Аялал жуулчлалын газар] нь эрх бүхий тендерт оролцогчдоос "Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх" /5 багцтай/ ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна. Үүнд:
- 1-р багц: Нийт төсөвт өртөг- 22969000 /хорин хоёр сая есөн зуун жаран есөн мянга/ төгрөг. Үүнд:
    1. Түүрүү тарьсан 6944 ш модны усалгаа, арчилгааны ажил-15624000 /арван таван сая зургаан зуун хорин дөрвөн мянга/ төгрөг
    2. Тов талбайн зүүн санданг нэмэлт тарилт хийх- 2535000 /хоёр сая таван зуун гучин таван мянга/ төгрөг
    3. Дөрвөлж толгой цэцэрлэгт хүрээлэнд нэмж мод тарих-4810000 /дөрвөн сая найман зуун арван мянга/ төгрөг
    - 2-р багц: Нийт төсөвт өртөг-20840000 /хорин сая найман зуун дөрчин мянга/ төгрөг. Үүнд:
      1. 5432 ш модны усалгаа, арчилгааны ажил-12222000 /арван хоёр сая хоёр зуун хорин хоёр мянга/ төгрөг
      2. Өнөр хороололын урд талбайд мод тарих- 2536000 /хоёр сая таван зуун гучин таван мянга/ төгрөг
      3. ХААн биржээс баруун тийш зам дагуу 500 ширхэг мод тарих ажил-1250000 /нэг сая хоёр зуун таван мянга/ төгрөг
      4. Баруун 4 замаас гүүр хүртэл замын хойд хэсгээр мод тарих-4732000 /дөрвөн сая долоон зуун гучин хоёр мянга/ төгрөг
    - 3-р багц: Нийт төсөвт өртөг-8680000 /найман сая зургаан зуун наян мянга/ төгрөг. Үүнд:
      1. 3370 ш модны усалгаа арчилгааны ажил-7582500 /долоон сая таван зуун наян хоёр мянга таван зуу/ төгрөг
      2. Эрчимийн уулзварын аралд мод тарих-1098000 /нэг сая ерэн найман мянга/ төгрөг
      - 4-р багц: Нийт төсөвт өртөг- 10133000 /арван сая нэг зуун гучин гурван мянга/ төгрөг. Үүнд:
        1. Уулзг тарих /Гандангийн урд тал-45 м<sup>2</sup>, Спорт хорооны зүүн тал-30м<sup>2</sup>, Номингийн баруун тал-50 м<sup>2</sup>, Хөсөгтэй тойрог-100м<sup>2</sup>, Өзлэйт

тойрог-105м<sup>2</sup>, 4 бэрх уулзвар-100м<sup>2</sup>, Худалдааны гудамжны суурь-20м<sup>2</sup>, Ордон баруун тал-680м<sup>2</sup>, 48-ын уулзвар-70м<sup>2</sup>, 27 орон сууцны дунд-400м<sup>2</sup> Нийт-1600м<sup>2</sup> газарт/ - 7310000 /долоон сая гурван зуун арван мянга/ төгрөг

    2. Наадмын талбайн зүлэгжүүлэлт - 2500м<sup>2</sup> газар болон гадна талын 4 сууринд зүлэг тарих ажил- 1700000 /нэг сая долоон зуун мянга/ төгрөг
    3. Гандангийн урд тал, Спорт хорооны зүүн тал, Номингийн баруун тал зэрэг газруудад зүлэг тарихаас гадна хайлаас, гүйлс, гөлтбөр 63 ш модыг тарих ажил- 1123000 /нэг сая нэг зуун хорин гурван мянга/ төгрөг
    - 5-р багц - нийт төсөвт өртөг- 9960000 /есөн сая есөн зуун жаран мянга/ төгрөг. Үүнд:
      1. Мод үржүүлгийн талбайн худгийн байшинг шинэчлэн засварлах ажил-9960000 /есөн сая есөн зуун жаран мянга/ төгрөг

**Баримт бичгийн үнэ:** 50,000 төгрөг.  
**Дансны дугаар:** Төрийн сан банк 100120013401 Байгаль орчин, аялал жуулчлалын газар  
 Үнийн саналыг [2017 оны 05 сарын 05-ны өдрийн 10 цаг 00 минут]-аас өмнө [Сүхбаатар аймгийн Нутгийн удирдлагын ордны 2-р байр 1 давхарт, Байгаль орчин, аялал жуулчлалын газар (01 тоот өрөө, М.Борчулуун-БОАЖ-ын мэргэжилтэн, 70518892, 99518826)] хаягаар ирүүлнэ.  
 Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байцлуулан [2017 оны 05 сарын 05]-ны өдрийн [10 цаг 30 минут]-т нээнэ.

**Дотоодын давуу эрх тооцох эсэх - Тооцно**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

Сүхбаатараймгийн Нутгийн удирдлагын ордны 2-р байр 1 давхарт, Байгаль орчин аялал жуулчлалын газар (01 тоот өрөө, мэргэжилтэн М.Борчулуун, Б.Цолмон 70518892, 99518826, 98836566)

## ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:



## Өдрийн зурхай

ХАВРЫН ТЭРГҮҮН  
ХАРАГЧИН ТУУЛАЙ  
САРЫН ТАВАН ШАР  
МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН  
МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл, ал, хэрүүл тэтгэл ирнэ

Наран ургах, шингэх:

05.43-20.02



Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн чанд зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсон баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

## “СААДТАЙ ХАРАЙЛТ”



Б.СУМЬЯА

Жил бүр зохион байгуулагддаг Дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “World press photo-2017” наадмын спортын төрлийн шилдгийн шагнал хүртсэн “Саадтай харайлт” сэдэвт зургийг уншигчиддаа сонирхуулж байна. Энэ зургийг 2016 оны дөрөвдүгээр сарын 9-нд авчээ. Энэ өдөр Их Британийн Ливерпулын

Эйнтри уралдааны талбайд “Гранд Нэйшл” саадтай харайлтын тэмцээн зохион байгуулагдсан байна. Улмаар тус тэмцээний үеэр удам дагасан унаач Нина Карберригийн мориноосоо унаж буй агшныг гэрэл зургийн торгон хальсанд ийн буулгажээ.

Зурагт хоёр морь дүрслэгдсэн байх аж. Баруун талд байгаа морь эхлээд бүдэрчээ. Дараа нь Нина Карберригийн морь дээгүүр нь харайх гэж байгаад

мөн л бүдрэн унаснаар унаач бүсгүй мориноосоо шидэгдэж буй тэрхүү агшны эгзгийг тааруулан дарсан нь энэ. Азаар энэ ослоор морь ч, унаач ч гэмтэж бэртээгүй гэнэ.

Энэ оны “Дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг” шалгаруулах тэмцээнд дэлхийн 125 орны 5034 зурагчин 80400 бүтээлээ илгээснээс Их Британийн гэрэл зурагчин Том Женкинсийн авсан дээрх зураг спортын төрөлд тэргүүджээ.

## СПОРТ

## Мария Шарапова гялалзаж эхэллээ

ОХУ-ын тамирчин, алдарт теннисчин Мария Шарапова сэргээш хэрэглэсэн гэж үндэслэлээр тэмцээнд оролцох эрхийг нь 15 сараар хассан байдаг. Харин саяхан түүний хориглосон хугацаа дуусч, нэрт тамирчин теннисний талбайдаа эргэн ирлээ.

Тэрбээр хамгийн сүүлчийн тэмцээнээсээ хойш жил гаруй хугацааны дараа Германы Штутгарт хотод зохион байгуулагдаж буй “Порше Теннис Гранд Прикс-2017” тэмцээнд оролцож, Италийн теннисчин Роберта Винситэй учраа таарч, 7:5, 6:3 харьцаагаар ялжээ. Мөн өчигдөр Екатерина Макароватай хоёр дахь тоглолтоо хийсэн байна. Оросын теннисчин М.Шарапова “Их дуулга”-ын тэмцээнүүдэд таван удаа түрүүлж байснаас гадна Холбооны цомд нэг удаа аваргалж, Лондонгийн Олимпын наадмаас мөнгөн медаль хүртэж байсан билээ. Эдүгээ 29 настай бүсгүй мелдониум эмийг Орос эмчийн заавраар 2006 оноос хойш хэрэглэсэн байдаг бөгөөд уг эмийг өнгөрсөн оноос тамирчдын эмчилгээнээс бүрэн хассан байдаг. Гэвч 2016 оны Австралийн теннисний нээлттэй тэмцээний үеэрх допингийн шинжилгээгээр түүний цуснаас мелдониум эмийн бодис илэрч, тэмцээнд оролцох эрхийг нь хассан юм.

## Бидэнд тохиолдсон

ХҮНДЭН ХӨГТЭЙ  
ЯВДЛУУД

Ж. Жина



Сая болсон хөгтэй явдлаа хуваалцмаар санагдлаа. Эмнэлэгт үзүүлж байтал зайрмаг идмээр санагдаад болдоггүй. Би долоон сартай жирэмсэн юм л даа. Тэгээд эмчдээ үзүүлчихээд дэлгүүрээс зайрмаг аваад, ганц хазаад байж байтал СУИС-ийн гадаа хөөцөлдөж байсан гурван залуу намайг түлхээд

миний зайрмаг газарт уначихлаа. Миний хоолой зангираад, нүдэнд дүүрэн нулимс цийлэгнэж ирснээ “Та нар яаж байгаа юм бэ” гээд л уйлж гарлаа. Яагаад уйлснаа өөрөө ч мэдэхгүй байна. Зайрмаг идэхийг л их хүссэн юм шиг байгаа юм. Тэгсэн нөгөө гурав чинь сандраад надад уут дүүрэн зайрмаг авч өглөө. Ккк

## Баяр хүргэж байна

Ж.Бямбадорж нь Дэлхийн Оюуны Өмчийн Академийн доктор (Ph.D) эрдмийн цол хүртсэнд баяр хүргэж байна.

ОХУ, АНУ, Чех, Швед,  
Швейцарь, Монгол Улс

2017.04.24

Дэлхийн Оюуны Өмчийн  
Академи

## ДУУЛГАХ СОНИН

## Хойд Солонгос жүдо бөхийн ДАШТ зохион байгуулахгүй

Солонгосын хойгт тогтворгүй байдал бий болсны улмаас Умард Солонгосын тал 2017 оны жүдо бөхийн залуучуудын ДАШТ-ийг зохион байгуулах эрхээ алдлаа. Умард Солонгосын нийслэл Пхеньян хот таван өдөр үргэлжлэх уг тэмцээнийг аравдугаар сарын 18-наас эхлэн зохион байгуулах эрхийг аваад байсан юм. Уг тэмцээнийг зохион байгуулах эрхийг Хорватын нийслэл Загреб хотод шилжүүлэх болсноо Олон улсын жүдогийн холбоо өчигдөр мэдэгдсэн байна. Тус холбооны мэдэгдэлд “Солонгосын хойгт үүссэн тогтворгүй байдлын улмаас энэ тэмцээнд тамирчдаа оролцуулахаас зарим улс орон татгалзаж, тамирчдынхаа аюулгүй байдалд санаа зовниж байгаагаа илэрхийлсэн учир нийм шийдвэр гаргалаа” гэж тайлбарлажээ.



МОНГОЛЫН АВТО МАСТЕРУУДЫН ХОЛБОО  
Замын-Үүд  
ХОТ